

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



ДУГААР 2024 / 3
СЭТҮҮЭГ

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛ



Аймаг, нийслэл, сум, дүүргийн
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

СОНГУУЛЬ

2024

САНАЛ АВАХ ӨДӨР

X.11

07⁰⁰-20⁰⁰



www.m-election.mn

GEEMongolia

Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо



АГУУЛГА

4

1.ДУГААРЫН ЗОЧИН

- Орон нутгийн сонгуулийн талаар ...
- Ц.Товуусүрэн: Иргэдийн хурлын төлөөлөгч иргэдэд илүү ойр, нийтлэг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах эрх зүйн боломжоор хангагдсан

8

2.ХУУЛЬ ТОГТООМЖ

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарь
- Хуулиас асууя, хуулиас хариулъя
- Сонгуулийн байгууллага

25

3. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

- Н.Наранцэцэг: Сонгогчдын нэрийн жагсаалтаас өөрийн мэдээллээс гадна санал авах байрныхаа хаягийг мэдэх боломжтой
- Сонгогчдын нэрийн жагсаалтаас та юу мэдэх вэ?

30

4.СОНГУУЛЬД ОРОЛЦОХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ

- Нам, эвслээс нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг
- Бие даан нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг

32

5. СУРТАЛЧИЛГАА

- Сонгуулийн сурталчилгаа
- Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар, дэлгэц ашиглах
- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих
- Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, хяналт тавих
- Сонгуулийн сурталчилгааны явцад хориглох зүйл

40

6.СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- С.Оюунтуяа: Амьдралд ойрхон шийдвэр гаргах хүмүүсийг сонгоно гэдэг утгаар хариуцлагатай хандаарай
- Саналын хуудас
- Зөөврийн хайрцгаар санал өгөх
- Сонгогч саналаа хэрхэн өгөх вэ?

45

7. ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол иргэд, залуус оролцоогоо хангах, төсөвт оролцох, засаглалд хяналт тавих хамгийн ойрхон боломж
- Сонгуульд оролцох нь үүрэг биелүүлэх биш эрхээ эдэлж байгаа хэрэг
- Сонгуулийн ажиглалт

49

8. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

- Б.Ууганцэцэг: Сонгуульд оролцогчдын бүртгэл, үйл ажиллагааны процессыг цахим системээр явуулна
- Сонгуулийн автоматжуулсан системийн баталгаажуулалт, хяналт
- Санал тоолох төхөөрөмжийн тухай

53

9.УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

- Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар холимог тогтолцоогоор 126 гишүүн сонголоо
- Ажиглагчдын дүгнэлтээс
- Сонгууль гэрэл зурагт



РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Референт-хэвлэлийн төлөөлөгч

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Улс төрийн мэдээлэл, арга зүйн газрын референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн тэргүүн

З.Бадмаараг

Сэтгүүлч

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн удирдах зөвлөлийн дарга

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.



ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ТАЛААР....



"УБТЗ" ХНН-ийн маркетингийн
албаны мэргэжилтэн
Д.ГАНЗОРИГ:



Монгол Улсын
Консерваторийн багш
Ц.БОЛОРЦОЛМОН:



Топ модель
Х.БАДАМГЭРЭЛ:

Төлөөллөөрөө дамжуулаад, шийдвэр гаргах түвшинд хамгийн ойроос оролцох боломж бол орон нутгийн сонгууль. Та ямар орчинд амьдрахыг хүсэж байна, Үндсэн хуулиар олж авсан эрхээ эдэлмээр байна уу. Тэгвэл сонгуульдаа идэвхтэй оролцоорой. Энэ бол өдөр тутмын амьдралын орчноо сайжруулах боломж юм шүү.

Орон нутгийн сонгууль бол ард түмэнтэй хамгийн ойр байж, иргэдээ хамгийн ойроос мэдэж, ойлгож, иргэдийн төлөө дуу хоолой болж ажилладаг хүмүүсийг сонгох чухал сонгууль. Надтай хамгийн ойр байж, миний өмнөөс төрийн анхан шатны удирдлагыг хэрэгжүүлэх хүнээ сонгож байна хэмээн ач холбогдол өгөөсэй. Мэдээж орон нутгийн сонгууль нь Улсын Их Хуралтай уялдаа холбоотой ажиллах том гүүр гэж бодож байна.

Орон нутгийн сонгууль нь бидний өдөр тутамдаа мэдэрдэг хардаг алхам тутамд тохиолддог, хамгийн ойрын асуудлуудыг шийдэхийн төлөө ажиллах хүмүүсийг сонгох сонгууль. 25 биш 18 хүрсэн хүн нэр дэвших боломжтой хэмээн хуульд өөрчлөлт оруулж залуучуудын оролцоог дэмжих хандлагатай байгаа нь таалагдаж байгаа



МУИС-ийн Улс төрийн мэдээлэл
харилцааны магистрант **Б.УЯНГА:**



"Эмоци" продакшны захирал,
МУСТА **Д.ТҮВШИНТӨР:**




Сүхбаатар дүүргийн "Зөгий үүр"
СӨХ-ын дарга **Б.ГАНЗОРИГ:**

Иргэд бид амьдрах орчноос эхлүүлээд өөрт хамааралтай олон асуудлыг шүүмжилсээр байдаг ч тэдгээрийг шийдэх боломжтой иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг сонгох сонгуульдаа хариуцлагагүй ханддаг. Та, биднийг төлөөлж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажиллах төлөөлөгчөө сонгохдоо маш няхуур хандаж, тэдний амлалтыг хянаж, нэхэж, эргэх холбоотой байх хэрэгтэй.

Бидний алхам тутамд тохиолддог, хамгийн ойрын асуудлуудыг шийдэхийн төлөө ажиллах хүмүүсийг сонгох сонгууль. Хог, орчны тохижилт, зам харгуй, цэцэрлэг сургууль гэх мэт зүйлсийг хариуцан, зөв шийдэл гаргах нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн ажил гэж ойлгоод байгаа. Тиймээс төрд байх бидний хамгийн ойрын төлөөлөл гэдэг үүднээс сонголтоо хийгээсэй гэж хүсэж байна.

Иргэдтэйгээ хамгийн ойр байж, тулж ажилладаг төлөөлөгчид бол иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байдаг. Тиймээс орон нутгийн сонгууль хамгийн чухал сонгууль. Иргэдээ сонсож чаддаг, тулгамдсан асуудлыг шийдэж чаддаг төлөөлөгчөө сонгох нь чухал. Амьдрах орчин, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гүүр шүү гэж ойлгож, сонгуульдаа идэвхтэй оролцоорой гэж хүсье.





Ц.ТОВУУСҮРЭН:

ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ ИРГЭДЭД ИЛҮҮ ОЙР, НИЙТЛЭГ СОНИРХЛЫГ ИЛЭРХИЙЛЭХ, ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН БОЛОМЖООР ХАНГАГДСАН

Улсын Бага Хурлын гишүүн, УИХ-ын гишүүн асан,
Үндсэн хууль судлаач Ц.Товуусүрэнтэй ярилцлаа.

-Үндсэн хуульд "Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна." гэж заасан байдаг. Ер нь нутгийн өөрөө удирдах байгууллага ямар чиг үүрэгтэй гэдгээс яриагаа эхэлье.

-Тиймээ, Үндсэн хуульд ингэж заасан хэдий ч манайхан нутгийн удирдлагын байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага гэсэн ялгаа бүхий нэр томъёонуудыг хооронд нь хольж хутгаж байгаа нь ажиглагддаг. Уг нь нутгийн өөрөө удирдах байгууллага гэдэг маань тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хуульд нийцүүлэн өөрөө шийдвэрлэж байх эрх бүхий байгууллага гээд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6-11 дүгээр зүйлд заасан байдаг. Харин Нутгийн удирдлагын байгууллага гэдэг нь Хурал, Засаг даргыг хамтад нь илэрхийлж байгаа юм. Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах гэдэг Үндсэн хуулийн ойлголт нь Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна." гэснээс үүдэлтэй юм. Үүнийг Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлд заасны дагуу Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна гэж зааснаар илэрхийлж

байгаа юм. Засаг даргын төрийн үүргийг ханган биелүүлэх зохицуулалт нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн "Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг"-ээр зохицуулагдаж байна. Нэг үгээр хэлбэл, Засаг дарга нэг талаас орон нутгийн Хурлын гүйцэтгэх байгууллага, нөгөө талаас хуульд заасны дагуу төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг засаг төрийн төлөөлөгч юм. Энэ бол манай улсын болон дэлхийн зарим улс орнуудын онцлог гэж ойлгож болно. Дэлхийн зарим улс орнуудад нутгийн удирдлагыг зөвхөн нутгийн удирдлагын байгууллагууд /орон нутгийн хурал, захирагч/ нь хэрэгжүүлж, төрийн удирдлагыг төв засгийн бүрэн эрхэт төлөөлөгч хэрэгжүүлдэг хэлбэр бий.

-Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг багасгасан парламент гэх нь ч бий. Ингэж ойлгож болох уу?

-Нэрээс нь харахад л Хурал бол иргэдийн байгууллага гэдэг нь ойлгомжтой. Хурлын гол үүрэг бол иргэдийн сайн сайхны төлөө үйлчлэх учиртай. Энд улс төрийн нам төвтэй бус, иргэд төвтэй үйл ажиллагаа ноёрхож байх учиртай. Цаашид ялангуяа сумын Хурлыг байгуулахад улс төрийн намын оролцоог хязгаарлаж, дэлхийн зарим улс орнуудад байдаг шиг иргэд сонгогчдын зөвлөлийн үүргийг өргөж өгөх шаардлага бий. Ингэвээс Хурал жинхэнэ утгаараа иргэдийн байгууллага болж, улс төрийн намаар талцан хуваагддаг гэж үзэгдэл мэдэгдэхүйц буурах болно.

-Иргэдийн Төлөөлөгчийн хурлын төлөөлөгч тухайн орон нутагт ямар үүрэг хүлээж, юу хийдэг вэ?

-Юуны өмнө Төлөөлөгч улс төрийн ашиг сонирхол илэрхийлэхгүй, өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхлыг илэрхийлэхгүй. Харин тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан. Бас энэ зүйлд тухайн Хурлаас баталсан ёс зүйн дүрмийг баримтална гэж заасан.

Төлөөлөгч асуудал хэлэлцэн батлахад таслах эрхтэй оролцох, Хурлын Хороонд харьяалагдах, Хуралд тодорхой асуудал санаачлан оруулж хэлэлцүүлэх, Засаг даргад нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлаар асуулт, асуулга тавих зэрэг үүрэгтэй байхаар мөн хуулийн 39 дүгээр зүйлд заасан байна.

Харин төлөөлөгч өөрийн олж авсан хувь хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх, өөр шатны Хурлын төлөөлөгч байхыг хориглосон байна.

-Тэгвэл Нийтийн Хурал гэж ямар чиг үүрэгтэй, гишүүд нь юу хийдэг хүмүүс вэ?

-Иргэдийн Нийтийн Хурал гишүүнчлэлгүй гэх үү дээ, гишүүн нь тухайн баг хорооны харьяат иргэд юм. Иргэд баг, хорооны түвшинд тулгамдаж байгаа асуудлаа Нийтийн хурлаар хэлэлцүүлэх, Нийтийн хурал түүнийг зохих шатны Хуралд хэлэлцүүлэхээр уламжлах, хууль, улс, аймаг, сумын шийдвэрт тухайлан заагаагүй асуудлаар бие даан шийдвэр гаргах, хадлан, бэлчээр, тариалан, уст цэгийн хамгаалалт, ашиглалт, байгаль орчны тэнцвэрт байдалд тавих иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх зэрэг асуудлаар иргэдийн нийтийн Хурлаас шийдвэр гаргах эрхтэй.

-Иргэдийн Төлөөлөгчдийн хурал манай гэрийн өмнөх зам, гэрэлтүүлэг, худаг ус гэх мэтэд иргэдийн өдөр тутмын амьдралд нөлөөлөхүйц шийдвэр гаргадаг уу?

-Тийм шийдвэр гаргана. Тухайлбал, тэдгээрийг шинээр байгуулах болон ашиглалтын үеийн зардлыг тухайн нэгжийн төсөвт тусган баталж, санхүүгийн эх үүсвэрийг нь шийдвэрлэнэ.

-Иргэд сонгох эрхээ эдэлж, нутгийн өөрөө удирдах байгууллагыг бүрдүүлдэг. Иргэдийн хувьд энэ нь хэр ач холбогдолтой вэ. Өөрөөр хэлбэл, сонгогдож ажиллах хүмүүс нь дугаар хорооны иргэн надад ямар хамааралтай вэ?

-Иргэд сонгох эрхээ эдэлж, Хурлын төлөөлөгчийг сонгох нь иргэний хувьд маш их ач холбогдолтой. Харин энэ ач холбогдлыг тулал нь ойлгож саналаа өгч байгаа эсэхэд асуудлын гогцоо бий. Ер нь иргэн өөрийнхөө төлөөллийг Хуралд сонгон суулгаж, тэр миний өмнөөс шийдвэр гаргана гэж бүрэн дүүрэн

ухамсарлаж сонголтоо хийх учиртай. Иргэдийн хувьд улсын Их Хурлын гишүүнээс Хурлын төлөөлөгчдөө ойр байж, тулгамдсан асуудлаа түүгээр дамжуулан шийдвэрлэх нь илүү шуурхай, бэрхшээл багатай гэдгийг ойрын ирээдүйд ухаарч ойлгох биз ээ.

-Хүмүүс Улсын Их Хурлыг өөрийг нь төлөөлөх байгууллага гэдэг нийтлэг ойлголттой. Харин орон нутгийн сонгуульд төдийлөн ач холбогдол өгөхгүй байна гэдэг судалгааны дүн байдаг юм билээ. Судлаачийн хувьд үүнийг хэрхэн дүгнэж байна вэ?

-Цаг хугацааны л асуудал даа. Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг дангаараа эдэлдэг. Түүний баталсан хууль иргэдийн ашиг сонирхолд нийцэж байна уу, үгүй юу гэдэг нь чухал болохоос иргэнийг шууд төлөөлдөг этгээд гэхэд арай л холдоно. Харин Хурлын төлөөлөгч бол илүү ойрхон, иргэдийн нийтлэг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах эрх зүйн боломжоор хангагдсан этгээд юм.

-Орон нутгийн сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй танилцаж, төлөөлөгчөө сонгох нь иргэдэд хэр ач холбогдолтой бол?

-Энд дахиад л нөгөө улс төрийн намын нөлөөлөл иргэдийг орон нутгийн Хурлын сонгуульд ач холбогдол өгдөг байхаас хөндийрүүлээд байж болох талтай. Иймээс ялангуяа сум, дүүргийн Хурлын сонгуульд тухайн сум, дүүргийн иргэдийн дунд нэр хүнд бүхий иргэдээс бүрдсэн сонгогч иргэдийн зөвлөлийг байгуулан ажиллуулж, дараагийн сонгуульд нэр дэвшүүлж өрсөлдүүлэх хүмүүсийг улс төрийн намын харьяалал харгалзахгүйгээр эртнээс судалж, бэлтгэдэг журамд шилжээсэй гэж хүсэж байна.

Орон нутагт улс төрийн намын албаны үг хэллэгтэй хуурай хөтөлбөрөөс илүүтэйгээр таны, миний эрх ашгийг хөндсөн тулгамдаж байгаа асуудлаар дэвшүүлсэн нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр чухал гэж үзнэ. Харин энэ хөтөлбөрийнхөө үзэл санааг Хурлынхаа хэлэлцэх асуудлын хүрээнд хамруулж, шийдвэрлүүлэх нь тухайн нэр дэвшигчийн арга барил, овсгоо самбаатай холбоотой.

-Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг холимог тогтолцоогоор явуулсан. Орон нутгийн сонгуулийн тогтолцоог Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоотой адил болгох шаардлага байгаа юу?

-Ийм шаардлагыг олж харахгүй байгаа. Орон нутгийн Хурал улс төрийн ашиг сонирхлыг илэрхийлэхгүй, тухайн нутаг дэвсгэрийн харьяат иргэдийн ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэсэн Төлөөлөгчдөөс бүрдэнэ гээд хуульд заасан учраас орон нутгийн сонгууль мажоритар тогтолцооны дагуу явуулахад зарчим алдагдахгүй гэж харж байна.

-Ярилцсанд баярлалаа.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС...

Арван зургадугаар зүйл.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

9/шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих

байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

Тавин есдүгээр зүйл.

3.Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

САНАЛ АВАХ ӨДӨР-2024.10.11

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль /орон нутгийн Хурлын сонгууль/ нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх үндсэн арга юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 19 дүгээр тогтоолоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр байхаар товлосон.

2024.10.11 өдрийн
07.00-20.00 цаг

2024

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦАГ ХУГАЦААНЫ ХУВААРЬ

Нэг. / СОНГУУЛИЙН ТОЙРОГ, ХЭСЭГ

2024.5.01 -ээс өмнө

Сонгууль товлон зарлах, санал авах өдөр тогтоох

Монгол Улсын Их Хурал орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн **05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно.

(Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг)

(Улсын Их Хурлын 2024 оны 19 дүгээр тогтоол)

2024.5.01 -ээс өмнө

Сонгуулийн тойрог байгуулах, мандатын тоо тогтоох

Тухайн шатны Хурал орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн **05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** нутаг дэвсгэрийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Хурлын төлөөлөгчдийн тоонд үндэслэн тойргийг байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.

(Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг)

2024.6.01 -ээс өмнө

Сонгуулийн хэсэг байгуулах

Сонгогчийн санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн **06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарлана.

(Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг)

Байгуулсан өдрөөс хойш 5 ХОНОГИЙН ДОТОР

Сонгуулийн хэсгийн талаарх мэдээллийг хүргүүлэх

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсгийг байгуулсан өдрөөс хойш **тав хоногийн дотор** энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлнэ.

(Хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг)

Нэгтгэж

5 ХОНОГИЙН ДОТОР

Сонгуулийн хэсгийн талаарх мэдээллийг хүргүүлэх

Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс энэ хуулийн 13.6-д заасан мэдээллийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн **тав хоногийн дотор** улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг)

Хоёр. / СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

2024.8.02-оос өмнө

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороог байгуулах

Аймаг, нийслэлийн Хурал санал авах өдрөөс **70-аас доошгүй хоногийн өмнө** аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг)

2024.8.12-оос өмнө

Сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс **60-аас доошгүй хоногийн өмнө** дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг)

2024.8.27-оос өмнө

Хэсгийн хороог байгуулах

Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс **45-аас доошгүй хоногийн өмнө** дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг)

Гурав. / СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

2024.8.12-оос эхлэн зогсоож,
2024.10.12-оос сэргээнэ

ИРГЭНИЙ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОГСООХ

Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг санал авах өдрөөс **60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс** сэргээнэ.

(Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг)

2024.7.13-аас эхлэн

Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст байршуулах

Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор болон сонгуулийн хэсэг нэг бүрээр нь нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг санал авах өдрөөс **90-ээс доошгүй хоногийн өмнөөс эхэлж** орон нутгийн Хурлын сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байршуулна.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг)

2024.8.12-оос өмнө

Эрх бүхий байгууллагууд сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэх

Доор дурдсан байгууллага дараах иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйс болон бусад шаардлагатай мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд санал авах өдрөөс **60-аас доошгүй хоногийн өмнө** цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ:

-эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Улсын дээд шүүх;

-хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа сонгуулийн насны иргэдийн мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

-60 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг хил хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

-тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй боловч санал авах өдөр харьяа тусгай анги, салбарт нь алба хааж

байгаа алба хаагч, ажилтны мэдээллийг хил хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

-тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд нь алба хааж байгаа алба хаагч, ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;

-тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй боловч тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд нь алба хааж байгаа алба хаагч, ажилтны мэдээллийг цагдаагийн төв байгууллага;

-тухайн жилд Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг)



2024.9.16-аас өмнө

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд хүргүүлэх

Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хуулийн 20.4-т заасны дагуу цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг тусган уг жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр үйлдэж, цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс **25-аас доошгүй хоногийн өмнө** улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ:

- сонгогчоос энэ хуулийн 20.4-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт;
 - энэ хуулийн 24.3-т заасан хугацаанаас өмнө хийгдсэн сонгогчийн байнга оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт;
 - сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар зэрэг иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;
 - нас барсан иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт;
 - энэ хуулийн 20.6-д заасан иргэдийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлт.
- (Хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг)

2024.09.27-оос өмнө

Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэлтэй эсэхээ шалгах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол гаргах

Сонгогч сонгогчийн нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн гэр бүлийн гишүүний мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол гомдлоо итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс **14-өөс доошгүй хоногийн өмнө** бичгээр гаргана.

(Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг)

Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ **санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө** шалгасан байвал зохино.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсэг)

Хүлээн авсан өдрөөс эхлэн СОНГОГЧ НЭРИЙН ЖАГСААЛТЫН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ

Хэсгийн хороо нь сонгогчдын нэрийн жагсаалтыг **хүлээн авсан өдрөөс эхлэн** өөрийн ажиллах байранд, байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд сонгогчийн өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

(Хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсэг)

2024.10.08-аас өмнө

Сонгогчийн мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах

Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн хуулийн 23.1-д заасны дагуу гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг санал авах өдрөөс **гурваас доошгүй хоногийн өмнө** сонгогчдын нэрийн жагсаалтад оруулна.

(Хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг)

Дөрөв. /НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

2024.8.12-оос өмнө

Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх

Нам, эвслийг төлөөлж тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх намын салбар байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, орон нутгийн Хурлын сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс **60-аас доошгүй хоногийн өмнө** тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ.

(Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг)

Хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор**НАМ, ЭВСЛИЙГ БҮРТГЭХ ЭСЭХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ**

Тухайн шатны сонгуулийн хороо сонгуульд оролцох тухай нам, эвслийн баримт бичгийг хүлээн авснаас хойш **тав хоногт багтаан** нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

(Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг)

2024.8.27-оос
2024.9.02-ыг дуустал**Нэр дэвшүүлэх ажиллагаа**

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс **45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн** хугацаанд дуусгана.

(Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг)

Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс **45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн** хугацаанд дуусгана.

(Хуулийн 28 дүгээр зүйлийн 28.2 дахь хэсэг)

2024.9.05-ны дотор

Нэр дэвшигчдийн баримт бичгийг ирүүлэх

Нэр дэвшүүлсэн нам, эвсэл хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш **гурав хоногт багтаан** ... баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ.

(Хуулийн 31 дугаар зүйлийн 31.2 дахь хэсгээс)

Бие даан нэр дэвшигч нь хуульд заасан бие даан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш **гурав хоногт багтаан** ... баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ.

(Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгээс)

Хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор**НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ ЭСЭХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ**

Сонгуулийн хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш **долоо хоногийн дотор** бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргана.

(Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.9 дэх хэсэг)

2024.9.26-ны өдөр

Нэр дэвшигчийн үнэмлэх олгох, нийтэд мэдээлэх

Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол тухайн шатны сонгуулийн хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс **15-аас доошгүй хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлнэ.**

(Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.10 дахь хэсэг)

Тав. / СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГАА

2024.6.25-аас өмнө
2024.7.25-аас өмнө

МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХААР ХҮРГҮҮЛЭХ

Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн **06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө**, бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн **07 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө** сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.
(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг)

2024.6.25-аас өмнө

**Хандивын тайландаа
дүгнэлт гаргуулахаар
хүргүүлэх**

Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн **06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө** хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.
(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг)

Дүгнэлт гарснаас хойш

5 ХОНОГИЙН ДОТОР

**Мөрийн хөтөлбөрт
дүгнэлт гаргуулахаар
дахин хүргүүлэх**

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд **тав хоногийн дотор** зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.
(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.9 дэх хэсэг)

2024.9.11-ээс өмнө

РАДИО, ТЕЛЕВИЗ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ТУХАЙ МЭДЭГДЛИЙГ ХҮРГҮҮЛЭХ

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг ... баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс **30-аас доошгүй хоногийн өмнө** хүргүүлж, бүртгүүлнэ.

(Хуулийн 45 дугаар зүйлийн 45.9 дэх хэсгээс)

2024.9.19-өөс өмнө

**Сурталчилгааны төлбөргүй
нэвтрүүлгийн хуваарь, цаг
батлах**

Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзэж, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс **долоогоос доошгүй хоногийн өмнө** батална.

(Хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг)

2024.8.12-оос өмнө

**Нам, эвслийн мөрийн
хөтөлбөрийн талаарх
дүгнэлтийг хүргүүлэх**

Төрийн аудитын байгууллага нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс **60-аас доошгүй хоногийн өмнө** гаргаж, тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.10 дахь хэсэг)

2024.8.12-оос өмнө

УХУУЛАХ ХУУДАС БАЙРЛУУЛАХ БАЙРШЛЫГ ТОГТООЖ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

Ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал санал авах өдрөөс **60-аас доошгүй хоногийн өмнө** тогтоож, нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг)

2024.9.06-аас өмнө

**Бие даан нэр
дэвшигчийн мөрийн
хөтөлбөрийн дүгнэлтийг
хүргүүлэх**

Төрийн аудитын байгууллага бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс **35-аас доошгүй хоногийн өмнө** гаргаж, тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.11 дэх хэсэг)

2024.9.19-өөс эхлэн

**Сонгуулийн мөрийн
хөтөлбөр, хандивын
тайлангийн талаарх
дүгнэлтийг цахим хуудаст
нээлттэй байршуулах**

Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага нь хуульд заасан нам, эвслийн хандивын тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс **22 хоногийн өмнөөс эхлэн** хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт нээлттэйгээр байршуулна.

(Хуулийн 37 дугаар зүйлийн 37.12 дахь хэсэг)

**2024.9.26-аас эхлэн
2024.10.09-ийг дуустал**

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ЭХЛҮҮЛЭХ, ЗОГСООХ

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид **үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж**, санал авах өдрөөс **24 цагийн өмнө** буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.
(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг)

2024.09.29-ий дотор

**Сонгуулийн
Сурталчилгаа явуулах
цахим хуудсыг
бүртгүүлэх**

Нэр дэвшигч хуулийн 46.1.1, 46.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн **үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор** тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

(Хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг)

2024.10.19-ий дотор

Сурталчилгаа явуулсан тайланг нийтэд мэдээлэх

Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгуулийн **сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор** сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлнэ.
(Хуулийн 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэг)

2024.08.17-ы өдрөөс

2024.10.07-ы өдрийг дуустал

Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан бүртгүүлэх

Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах хүсэлтийг тухайн нам, эвслийг бүртгэсэн тухай **шийдвэр гарснаас хойш сонгуулийн сурталчилгаа дуусахаас 2 хоногийн өмнөх өдрийг хүртэлх хугацаанд** дараах байдлаар хүргүүлнэ:
- аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд;
- сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг сум, дүүргийн сонгуулийн хороонд.
(Хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.6 дахь хэсэг)
(Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 17 дугаар тогтоолоор баталсан журам)

2024.09.13-ы өдрөөс

2024.10.07-ыг дуустал

Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар бүртгүүлэх

Нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн үнэмлэх авах хүсэлтийг нэр дэвшигчийг бүртгэсэн тухай **шийдвэр гарснаас хойш сонгуулийн сурталчилгаа дуусахаас 2 хоногийн өмнөх өдрийг хүртэлх хугацаанд** дараах байдлаар хүргүүлнэ:
- аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд;
- сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг сум, дүүргийн сонгуулийн хороонд.
(Хуулийн 36 дугаар зүйлийн 36.5, 36.6 дахь хэсэг)
(Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 17 дугаар тогтоолоор баталсан журам)

2024.10.06-аас өмнө

АЖИГЛАГЧ БҮРТГҮҮЛЭХ

Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бичгээр гаргаж, **санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ.**
(Хуулийн 66 дугаар зүйлийн 66.7 дахь хэсэг)

2024.10.09-өөс өмнө

Ажиглагчийн үнэмлэх олгох

Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, **санал авах өдрөөс хоёроос доошгүй хоногийн өмнө** ажиглагчийн үнэмлэх олгоно.
(Хуулийн 66 дугаар зүйлийн 66.9 дэх хэсэг)

Зургаа. / САНАЛ АВАХ, ДҮН ГАРГАХ

2024.09.27-оос эхлэн санал авах өдрийг дуустал

САНАЛ АВАХ ӨДӨР, ЦАГ, БАЙРЫГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

Хэсгийн хороо нь санал авах байрны дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг **санал авах өдрийг хүртэлх 14 хоногийн турш** нийтэд зарлан мэдээлнэ.
(Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7 дахь хэсэг)

2024.10.04-өөс өмнө

Санал авахад шаардлагатай зүйлсийг бэлэн болгох

Тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс **долоогоос доошгүй хоногийн өмнө** бэлэн болгох үүрэгтэй.
(Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг)

2024.10.08-аас өмнө

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ байгууллагын удирдлагад болон хэсгийн хороонд хүргүүлэх

Эрүүл мэндийн байдлын улмаас зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх харьяа өрхийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс **гурваас доошгүй хоногийн өмнө** хэсгийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг)

2024.10.04-өөс өмнө

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ байгууллагын удирдлагад болон хэсгийн хороонд хүргүүлэх

Энэ хуулийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.4-т заасан сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад өгөх бөгөөд байгууллагын удирдлага уг хүсэлтийг байгууллагын тодорхойлолтын хамт санал авах өдрөөс **долоогоос доошгүй хоногийн өмнө** сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэг)

2024.10.06-аас өмнө

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ байгууллагын удирдлагад болон хэсгийн хороонд хүргүүлэх

Сум, дүүргийн сонгуулийн хороо энэ хуулийн 62.4-т заасны дагуу ирүүлсэн хүсэлт, тодорхойлолтыг санал авах өдрөөс **таваас доошгүй хоногийн өмнө** тухайн сонгогчийн харьяалагдах хэсгийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсэг)

Долоо. / СОНГУУЛИЙН ЗАРДАЛ, ТАЙЛАН

2024.10.06-аас өмнө

Ажиглагчаар бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлэх

Ажиглагч томилох эрх бүхий этгээд ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу бичгээр гаргаж, санал авах өдрөөс **таваас доошгүй хоногийн өмнө** хэсгийн хороонд хүргүүлнэ.

(Хуулийн 66 дугаар зүйлийн 66.7 дахь хэсэг)

2024.10.08-аас өмнө

Саналын хуудсыг санал авах байранд хүргүүлэх

Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудсыг санал авах өдрөөс **гурваас доошгүй хоногийн өмнө** санал авах байранд хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

(Хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг)

2024.10.09-өөс өмнө

Ажиглагчийн үнэмлэх олгох

Хэсгийн хороо хүсэлтийг хүлээн авч нягтлан шалгаж, санал авах өдрөөс **хоёроос доошгүй хоногийн өмнө** ажиглагчийн үнэмлэх олгоно.

(Хуулийн 66 дугаар зүйлийн 66.9 дэх хэсэг)

2024.7.01-ээс өмнө

Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоох

Энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн **07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө** тогтоож, нийтэд мэдээлнэ. (Хуулийн 49 дугаар зүйлийн 49.1 дэх хэсэг)

2024.9.21-ээс өмнө

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлэх

Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс **20-оос доошгүй хоногийн өмнө** төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

(Хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг)

Нам, эвсэл

2024.11.25-ы дотор

Нэр дэвшигч

2024.11.10-ы дотор

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛЭХ

Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш **45 хоногт**, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш **30 хоногт багтаан** зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэг)

2024.10.10-ы

09:00-20:00 цаг

Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах

Өөрийн байнга оршин суугаа сум болон нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа ... сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн **санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд** авна.

(Хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгээс)

2024.10.11-ий өдрийн
07:00-20:00 цаг

САНАЛ АВАХ ӨДӨР, ЦАГ

Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар **санал авах өдрийн 07:00-20:00 цаг хүртэл хугацаанд** санал авах байранд авна.

(Хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг)

2024.10.18-ы дотор

Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг өргөн мэдүүлэх

Тухайн шатны сонгуулийн хороо сонгуулийн дүн болон Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай шийдвэрийг **сонгууль дууссанаас хойш долоо хоногийн дотор** тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

(Хуулийн 73 дугаар зүйлийн 73.4 дэх хэсэг)

2024.11.10-ы дотор

Гүйлгээний хуулга гаргаж, аудитын байгууллагад хүргүүлэх

Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш **30 хоногийн дотор** төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.

(Хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэг)

Нам, эвсэл

2025.01.24-ий дотор

Нэр дэвшигч

2025.01.09-ий дотор

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛЭХ

Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш **60 хоногийн дотор** хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

(Хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэг)

ХУУЛИАС АСУУЯ ХАРИУЛЪЯ



-ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ ХЭДЭН НАСНААС ҮҮСДЭГ ВЭ?

-Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий Монгол Улсын үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр орон нутгийн Хурлын сонгуульд оролцож, тухайн шатны Хурлын Төлөөлөгчийг сонгох эрхтэй.

18 нас хүрсэн, ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, хуульд заасан шаардлага хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.



-САНАЛ ӨГӨХ БАЙРАА ХААНААС МЭДЭХ БОЛОМЖТОЙ ВЭ?

-Сонгогч та сонгогчийн нэрийн жагсаалт дахь мэдээллээ <https://election.burtgel.gov.mn/> цахим хаягаар шалгахад санал өгөх байрыг заасан байдаг. Хэсгийн хороо нь санал авах байрны дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг санал авах өдрийг хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ. Түүнчлэн "e-election" цахим сан, гар утасны апплейкшнаас мэдээлэл авах боломжтой.



-ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН САНАЛАА ӨГӨХӨД БЭРХШЭЭЛ БИЙ ЮУ?

-Санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байдаг. Түүнчлэн харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна.



-СОНГОГЧИЙН ӨГСӨН САНАЛЫГ ХӨНДЛӨНГӨӨС МЭДЭХ ЭРСДЭЛТЭЙ ЮУ?

-Иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглодог. Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргана. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй бөгөөд Таныг нууцаар саналаа өгөх бүх боломжийг бүрдүүлдэг.



-САНАЛ АВАХ БАЙРАНД СОНГОГЧ САНАЛАА ӨГӨХӨД ТУСЛАХ АЖИЛТАН БИЙ ЮУ?

-Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн

хүний туслалцаатайгаар саналаа өгч болно. Итгэмжилсэн хүн хоёроос дээш сонгогчид туслалцаа үзүүлэхийг хориглоно. Сонгуулийн байгууллагын ажилтан, нэр дэвшигч, ажиглагч, улс төрийн албан тушаалтан нь итгэмжилсэн хүн байж болохгүй.



-СОНГОГЧ САНАЛАА ТЭМДЭГЛЭХДЭЭ АЛДАА ГАРГАСАН БОЛ ЯАХ ВЭ?

-Сонгогч саналаа тэмдэглэхдээ алдаа гаргаж, буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхээс өмнө энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа өгч болно. Хэсгийн хороо хураалгасан саналын хуудасны зүүн доод өнцгийг хайчлан, тэмдэглэл хөтлөн хадгалдаг.



-СОНГОГЧ САНАЛЫН ХУУДСАА ОЛОН НИЙТЭД ХАРУУЛЖ БОЛОХ УУ?

-Сонгогч саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах зэрэг үйлдэл гаргах, саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах, зориулалтын бус үзгээр санал тэмдэглэх нь хориотой. Түүнчлэн аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө,




-САНАЛ АВАХ ӨДӨР АЖИЛТАЙ БАЙЖ ТААРВАЛ ЯАХ ВЭ?

-Тухайн байгууллагын удирдлага чөлөө олгож, санал өгөх боломжоор хангах үүрэгтэй. Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчийг санал өгөх боломжоор хангах үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг (10 сая)-өөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг (100 сая)-өөр торгоно. Таны сонгох эрхийг хангаагүй бол гомдол гаргах бүрэн боломжтой.



-СОНГОГЧИД ЭД ЗҮЙЛ, БЭЛЭН МӨНГӨ ТАРААСНЫГ МЭДВЭЛ ЯАХ ВЭ?

-Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно. Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.



“
АЙМАГ, НИЙСЛЭЛ,
СУМ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024
ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛИЙН
ТОЙРОГ, МАНДАТ

Тухайн шатны Хурал нутаг дэвсгэрийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Хурлын төлөөлөгчийн тоонд үндэслэн тойргийг байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоодог.



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТ

№	Аймаг, дүүрэг	Хэсгийн тоо /2024/	Мандатын тоо /2024/			
			Аймаг, нийслэл Тойрог	Мандатын тоо	Сум, дүүрэг Тойрог	Мандатын тоо
1	Архангай	105	41	41	99	423
2	Баян-Өлгий	100	33	41	100	317
3	Баянхонгор	106	29	35	105	416
4	Булган	75	21	29	76	338
5	Говь-Алтай	88	27	29	88	356
6	Говь-Сүмбэр	10	8	25	10	65
20	Дархан	45	21	41	26	96
7	Дорноговь	70	22	35	65	274
8	Дорнод	75	24	35	67	284
9	Дундговь	68	23	25	62	291
10	Завхан	115	29	35	115	444
21	Орхон	43	26	41	28	50
11	Өвөрхангай	113	39	41	112	435
12	Өмнөговь	63	24	35	61	291
13	Сүхбаатар	67	21	29	67	274
14	Сэлэнгэ	63	17	41	57	383
15	Төв	100	32	35	97	527
16	Увс	94	30	35	93	399
17	Ховд	91	28	41	90	367
18	Хөвсгөл	129	37	41	128	511
19	Хэнтий	92	26	35	89	384
Аймгийн дүн		1712	558	745	1635	6925
22	Багануур	11	12	45	2	25
23	Багахангай	2			8	25
24	Баянгол	82			34	41
25	Баянзүрх	124			43	43
26	Налайх	14			8	25
27	Сонгинохайрхан	109			43	43
28	Сүхбаатар	49			10	35
29	Хан-Уул	74			16	41
30	Чингэлтэй	50			20	35
Нийслэлийн дүн		515			184	313
Улсын дүн		2227	570	790	1819	7238

Нийт мандатын тоо /Аймаг, нийслэл, сум дүүрэг/ 8028

СОНГУУЛИЙН
БАЙГУУЛЛАГА

Орон нутгийн Хурлын сонгуулийг аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд сум, дүүргийн сонгуулийн хороо, сонгуулийн хэсэгт хэсгийн хороо зохион байгуулж явуулна.



СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО

Сонгуулийн ерөнхий хороо нь орон нутгийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХУРАЛ

2024.08.02-ы өдрөөс өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

-Аймаг, нийслэлийн хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, үнэмлэх олгох;

-Саналын хуудаст бичигдэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй тулган нягталж, баталгаажуулан үнэн зөвийг хариуцах;

-Аймаг, нийслэлийн хурлын сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, нийтэд мэдээлэх;

-Аймаг, нийслэлийн хурлын төлөөлөгчөөр сонгогдсон тухай шийдвэрийг аймаг, нийслэлийн хуралд өргөн мэдүүлэх;

-Аймаг, нийслэлийн хурлын сонгуулийн нэмэлт санал хураалт, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулж явуулах ажлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд хуульд заасны дагуу зохион байгуулах;



-Сум, дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалтын хувьд нэгдсэн удирдлагаар хангах;

-Сум, дүүргийн сонгуулийн хорооны ээлжит, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль, нэмэлт санал хураалтын үеийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

-Сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

-Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

-Саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

-Аймаг, нийслэлийн хурлын сонгуульд харьяалах сонгуулийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг бүрэн эрхийн хүрээнд хянан шийдвэрлэх, хариуг бичгээр өгөх, доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох;

-Санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу хүргүүлэх;

-Сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах, дахин сонгуулийг товлон зарлах;

-Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд өгсөн үүргийг биелүүлэх;

-Бусад.



СУМ, ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ 2024.08.12-ы өдрөөс өмнө дарга, нарийн бичгийн дарга болон гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

-Сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;

-Сум, дүүргийн хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, үнэмлэх олгох;

Сум, дүүргийн хурлын сонгуулийн саналын хуудаст бичигдэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй тулган нягталж, баталгаажуулан үнэн зөвийг хариуцах;

-Сум, дүүргийн хурлын сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, нийтэд мэдээлэх;

-Сум, дүүргийн хурлын төлөөлөгчөөр сонгогдсон тухай шийдвэрийг аймаг, нийслэлийн хуралд өргөн мэдүүлэх;

-Нутаг дэвсгэртээ явагдсан аймаг, нийслэлийн хурлын сонгуулийн дүнг нэгтгэж, дээд шатны сонгуулийн хороонд хүргэх;

-Сум, дүүргийн хурлын нэмэлт санал хураалт, ээлжит бус, дахин болон нөхөн сонгууль зохион байгуулж явуулах ажлыг эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

-Харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

-Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг гаргах, зарцуулалтад хяналт тавих;

-Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгөх;

-Харьяалах хэсгийн хорооноос ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргэх;

-Дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

-Сонгуулийн баримт бичгийг сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;

-Саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

-Хуульд заасан бусад.



ХЭСГИЙН ХОРОО

СУМ, ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО ХЭСГИЙН ХОРООГ 2024.08.27-ы өдрөөс өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

-Хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

-Санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах төхөөрөмж /цаашид "санал тоолох төхөөрөмж" гэх/ зэрэг санал авахад шаардлагатай бусад


зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

-Санал хураалтын дүнг танилцуулах, нэн даруй дамжуулах;

-Сонгуулийн баримт бичгийг сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;

-Дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;

-Хуульд заасан бусад чиг үүрэг.



Н.НАРАНЦЭЦЭГ:

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТААС ӨӨРИЙН МЭДЭЭЛЛЭЭС ГАДНА САНАЛ АВАХ БАЙРНЫХАА ХАЯГИЙГ МЭДЭХ БОЛОМЖТОЙ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт, иргэний шилжилт хөдөлгөөний талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэгтэй ярилцлаа.

-Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим санд байршуулсан. Цахим сан дахь сонгогчдын мэдээлэл Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеийнхээс юугаараа өөр вэ?

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг 2024 оны 7 дугаар сарын 13-ны өдрөөс байгууллагын цахим хуудаст байршуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгогчийн танилцах мэдээлэл ижил. Өөрөөр хэлбэл, сонгогч эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээлэл зөрүүтэй эсхүл буруу бүртгэгдсэн эсэхийг нягтлан шалгах хуулийн зохицуулалттай.

Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сонгогч цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжтой болсон.

Энэ зохицуулалт Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд тусгагдаагүй тул сонгогч цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтаас зөвхөн өөрт нь холбогдох мэдээлэлтэй танилцах боломжтой байна гэсэн үг. Мэдээлэл нь зөрүүтэй бол өөрийн оршин суугаа газрынхаа улсын бүртгэлийн хэлтэст хандана гэж ойлгож болно.

-Улсын Их Хурлын сонгуулиар сонгогчдын хэдэн хувь нь мэдээллээ шалгасан бол. Манай хаяг дээр танихгүй хүн байна, мэдээлэл зөрүүтэй байна гэх яриа гардаг. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар ийм гомдол их гарсан уу. Хэрхэн шийдэгдсэн бол?

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтын холбогдох мэдээлэлтэй 2024 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 136.063 иргэн танилцсан ба мэдээлэл зөв гэсэн 128.548, мэдээлэл зөрүүтэй 7517, шийдвэрлэсэн 1286 байна.

Нийт гомдлын 6179 буюу 82 хувийг өөрийн хаягт оршин сууж байгаа иргэний тоо зөрүүтэй буюу тухайн иргэний хаяг дээр танихгүй иргэн бүртгэлтэй байна гэсэн гомдол эзэлж байсан. Энэ гомдлыг шалгаж үзэхэд, ихэвчлэн тухайн эд хөрөнгийн өмнөх эзэмшигч иргэн бүртгэлтэй байгаад байна. Тэгэхээр үл хөдлөх эд хөрөнгөө /байр, хашаа байшин зэрэг/ худалдан борлуулсан иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгэхгүй хуучин хаяг дээрээ байгаад байгаа юм.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийг 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт “Иргэний оршин суугаа газрын үл хөдлөх эд хөрөнгийн болон газар өмчлөх эрх нь дуусгавар болсон боловч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бүртгэлд өөрчлөлт ороогүй бол холбогдох иргэний хүсэлтийг үндэслэн гаргасан хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийг түдгэлзүүлж болно” гэсэн хуулийн зохицуулалт байгаа. Үүний дагуу өмчлөгч иргэн тухайн нэгжийн хяналтын улсын байцаагчид хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх боломжтой.

Уг зөрчлийг шийдвэрлэхэд Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэн ажиллах тул тодорхой хугацаа шаардлагатай гэдгийг хэлмээр байна.

Түүнчлэн нөгөө талаар өмчлөгч иргэн өөрөө хүсэлт гаргаад ах, дүү хамаатан садныхаа ялангуяа хүүхэд сургууль, цэцэрлэгт бүртгүүлэх нэрээр тухайн иргэнийг албан ёсоор бүртгүүлсэн атлаа түүнийгээ мартсан байна гэх асуудал ч бас цөөнгүй гарсан гэдгийг хэлмээр байна. Иймд мэдээллийг зөв шалгаж гомдол гаргах нь зүйтэй юм.

-Хаягийн бүртгэлтэй холбоотой ямар зөрчлүүд ихэвчлэн байсан бэ?

-Ихэвчлэн оршин суугаа хаяг дээр өөр иргэн бүртгэлтэй байна гэсэн гомдол байлаа. Иргэд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дүрэм, журмыг сайн мэдэхгүй байгаагаас бүртгэлээ хийлгэхгүй байх шиг байна. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу иргэн шилжин суурьшихдаа холбогдох эх нотлох баримт бичгийг бүрдүүлж, оршин суух газрынхаа улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ гэсэн хуулийн заалт байдаг. Иргэн өөрийн биеэр оршин суух газрынхаа улсын бүртгэгчид хандан шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэхийн зэрэгцээ төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-ээр дамжуулан бүртгэлээ хийлгэх боломжтой байгаа.

-Их Хурлын сонгуулиар багагүй гомдлыг шийдвэрлэсэн бол орон нутгийн сонгуулиар хаяг бүртгэлтэй холбоотой зөрчил багассан гэж ойлгож болох болов уу?

-Тиймээ, зөрчил тодорхой хэмжээгээр багассан гэж ойлгож болно. Гэхдээ шалгах, тодруулах шаардлагатай өргөдөл гомдолд хугацаа хэрэгтэй гэдгийг дахин хэлмээр байна.

-Мэдээлэл зөрүүтэй бол цахим сангаар гомдол гаргаад засуулахад хэр хугацаа орох вэ?

-Иргэний өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг баримтлан шийдвэрлэж ажиллана.

Гомдол гаргасан сонгогчийн мэдээллийг архивын эх нотлох баримт бичгийг үндэслэн тухай бүр шийдвэрлэх боломжтой бол шийдвэрлээд иргэнд хариу мэдэгдэнэ. Харин мэдээллийг нягтлан шалгах, тодруулах шаардлагатай бол тодорхой хэмжээний хугацаа шаардана.

-Сонгогчдын нэрийн жагсаалт танай цахим санд хэдийг хүртэл байрших вэ. Иргэд хэзээг хүртэл мэдээллээ шалгаж, зөрүүтэй бол гомдол гаргах боломжтой бол?

-Цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай сонгуулийн санал авах өдрийг дуустал танилцаж, өөрийн мэдээллээс гадна санал өгөх байрныхаа хаягийг харах боломжтой. Харин гомдол гаргах хугацаа хуульд заасны дагуу сонгуулийн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө гэдгийг анхаарах хэрэгтэй. Энд нэг зүйл анхааруулж хэлэхэд, дээр дурдсанчлан хуульд заасан 14 хоногийн хугацаа дууссан гээд асуудлыг шийдвэрлэхгүй гэсэн үг биш юм. Сонгуулийн дараа иргэний журмаар харьяалах улсын бүртгэлийн хэлтэст хандаж асуудлыг шийдвэрлүүлэх бүрэн боломж байгааг хэлэх нь зүйтэй байх.

-Цахимаар мэдээллээ шалгах боломжгүй иргэд хэсгийн хороондоо очоод мэдээлэл авах боломжтой юу. Хэзээнээс сонгогчдын мэдээлэл хэсгийн хороонд очих вэ?

-Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ... цаасан хэлбэрээр үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ” гэж заасан. Тэгэхээр сонгогчдын нэрийн жагсаалтыг 2024 оны 9 дүгээр сарын 16-ын өдрөөс өмнө хэвлэж, сонгуулийн хэсгийн хороодод цаасан хэлбэрийн нэрийн жагсаалтыг хүргүүлнэ. Энэ үеэс эхлэн цахимаар мэдээллээ шалгах боломжгүй сонгогч сонгуулийн хэсгийн хороон дээр очиж сонгогчдын нэрийн жагсаалттай танилцаж болно.

-Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл сонгогчдын нэрийн жагсаалтыг өгдөг. Нам, эвслээс сонгогчидтой холбогдож хэнд санал өгөхийг асуудаг, зөвлөсөн гэх мэдээлэл сошиал багагүй гарсан. Сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн иргэний хувийн мэдээлэл ордог уу. Ер нь ямар мэдээллийг нам, эвслүүдэд өгдөг вэ?

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтээр цахимаар нэг удаа, Монгол Улсын Их Хурлын сонгуулиар сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтээр цахимаар 2 удаа олгох хуулийн зохицуулалт бий. Харин Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд сонгогчдын нэрийн жагсаалтыг нам, эвсэлд өгөх зохицуулалт байхгүй.

-Орон нутгийн сонгуулиар иргэний шилжилт хөдөлгөөн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох зохицуулалт Их Хурлын сонгуулийнхтай адил уу.

-Тиймээ, адил. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сонгуулийн санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс зогсоосон.

-Нам, эвслүүдээс иргэний шилжилт хөдөлгөөн, бүртгэлтэй холбоотой “царцааны нүүдэл”, “хаягийн зөрчил” гэх мэт мэдээлэл хийдэг. Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар улс төрийн намуудтай цөөнгүй уулзалт, танилцуулга хийсэн. Ойлголтын зөрүүг арилгасан болов уу?

-Энэ бол яах аргагүй ярих асуудлын нэг. Энэ тал дээр улс төрийн нам, эвсэл буруу ойлголттой байдаг. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл иргэний улсын бүртгэлийн нэг төрөл бөгөөд тодорхой эх нотлох бичиг баримтыг үндэслэдэг. Улсын бүртгэлийн байгууллага хэн нэг хүний оршин суугаа хаягт замбараагүй олон иргэнийг ямар ч зөвшөөрөлгүй бүртгээд байдаггүй, эрх бүхий байгууллагаас олгосон хаяг дээр эх нотлох баримтыг үндэслэн бүртгэл хөтөлдөг гэдгийг ойлгох хэрэгтэй. Улсын бүртгэлийн байгууллагын дотоод хяналт шалгалт хариуцсан нэгж бүртгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулж ажилладаг. Үүний нэг адил шилжилт хөдөлгөөний бүртгэлд ч мөн тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үеэр хуулийн хэрэгжилтийг хангаж улс төрийн нам, эвсэлтэй нийт 5 удаа уулзалт зохион байгуулж ажилласан.

Уулзалтаар сонгогчдын нэрийн жагсаалтад нас барсан, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаж, сонгогчдын нэрийн жагсаалтад шинээр нэмэгдсэн,

овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсөн, эрх бүхий этгээдийн шийдвэрээр регистрийн дугаар өөрчилсөн, Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяалал сэргээн тогтоосон, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгэгдсэн зэрэг иргэдийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэсэн байдал, уг бүртгэлийн дагуу сонгогчийн бүртгэлд өөрчлөлт орж байгаа мэдээллийг нэг бүрчлэн үзүүлж, холбогдох тайлбарыг өгч, сонгогчийн бүртгэлийн сан, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан нэг гэдгийг баримтаар нотлон харуулсан.

Түүнчлэн нам, эвсэл, төрийн бус байгууллагаас сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхтэй холбоотой гарч байгаа асуудал, иргэний хаягт бүртгэлтэй байгаа өөр иргэнийг шалгуулах, иргэн амьдардаггүй хаяг зохиомлоор үүсгэн сонгогч бүртгэсэн зэрэг зөрчлийг мэдээлсний дагуу асуудлыг газар дээр нь мэдээллийн санд эх нотлох баримт бичигтэй тулган шалгаж, хариу өгч ажилласан.

Мөн сонгуулийн өмнө улс төрийн нам, эвслийн төлөөллийг оролцуулан нам, эвсэлд өгсөн сонгогчдын нэрийн жагсаалтын баазыг лацдан битүүмжилж, Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийн дараа буюу 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдөр лацдаж хадгалсан баазыг мэдээллийн сангийн үндсэн баазтай тулгаж, сонгогчийн бүртгэл давхардсан эсэхийг улс төрийн нам эвслийн төлөөллийн хамт нягтлан шалгасан.

Үүний үр дүнд мэдээллийн санд ямар нэг зөрчил дутагдал байхгүй, нэг сонгогч нэг хэсэгт байна гэдгийг шалгаж тогтоон баталгаажуулсан.

Нам, эвсэл, төрийн бус байгууллагын хүсэлтээр сонгогчийн ирц бүртгэлийн программ хангамжид сонгогчийг бүртгэх, бүртгэсэн мэдээллийг дамжуулах нэгдсэн санд бүртгэсэн мэдээлэл хэрхэн ямар байдлаар төв серверт харагдаж байгаа талаар сонгуулийн хэсгийн хороон дээр туршилт хийж танилцуулах үйл ажиллагаа зэргийг зохион байгуулсан нь ихээхэн үр дүнтэй ажил болж ойлголтын зөрүүг арилгасан гэж бодож байна.

-Орон нутгийн сонгуульд хэчнээн сонгогч санал өгөх вэ?

-Орон нутгийн сонгуульд 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 2,246.511 сонгогч бүртгэгдсэн байна.

Энэ тоо сонгуулийн санал авах өдрийг хүртэл өөрчлөгдөнө гэж ойлгох хэрэгтэй. Нас барсан иргэн хасагдана, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан бол нэмэгдэж орно мөн төрийн байгууллагын мэдээллийн дагуу нэмэлт тэмдэглэгээ хийгдэх зэргээс шалтгаалж тоо өөрчлөгдөнө.

Ярилцсанд баярлалаа

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТААС ТА ЮУ МЭДЭХ ВЭ?

Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлддэг.

Сонгогч Та сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс

14-өөс доошгүй хоногийн өмнө
(2024.09.27-оос өмнө)
шалгасан байвал зохино.

Мэдээллээ хэрхэн шалгах вэ?

1-Р АЛХАМ:

Та Улсын бүртгэлийн ерөнхий газрын <https://election.burtgel.gov.mn/> цахим санд Иргэний бүртгэлийн дугаар эсхүл регистрийн дугаараа бичиж бүртгэлтэй хаяг цонхонд оршин суугаа аймаг (нийслэл), сум (дүүрэг), баг (хороо)-ийг сонгож “шалгах” товчийг дарна.

2-Р АЛХАМ:

“Шалгах” товчийг дарснаар Таны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, нас, хүйс, дэлгэрэнгүй хаяг, үндсэн хаяг дээрээ байгаа эсэх төлөв, сонгуулийн хэсгийн дугаар, санал өгөх байрны хаяг, тухайн хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо гарна.

3-Р АЛХАМ:

“Сонгогчийг харах” сонголтыг идэвхжүүлснээр танай хаягт бүртгэлтэй сонгогчдын нэр гарна.

4-Р АЛХАМ:

Таны мэдээлэл зөв бол “мэдээлэл зөв” сонголтыг хийнэ.

Мэдээлэл зөв

Мэдээлэл зөрүүтэй бол яах вэ?

1-Р АЛХАМ:

Зөрүүтэй буюу буруу мэдээллийн арын сумыг дарж идэвхжүүлнэ. Жишээ нь таны оршин суугаа хаяг зөрүүтэй бол “Дэлгэрэнгүй хаяг”, танай хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо зөрүүтэй бол “сонгогчийн тоо” гэсэн мэдээллийн арын сумыг хойш түлхэж идэвхжүүлнэ. Ингэснээр “зөрүүтэй мэдээлэл” цэс улаан өнгөтэй болж, дарахад идэвхэжнэ.

2-Р АЛХАМ:

“мэдээлэл зөрүүтэй” хэсгийг идэвхжүүлснээр таны мэдээлэл, гомдол бичих цонх гарч ирнэ. Энэ хэсэгт та идэвхитэй ашигладаг холбоо барих дугаар болон и-мэйл хаягаа бичнэ үү. Нэмэлт тайлбар цонхонд мэдээлэл, гомдлынхоо утгыг бичээд “илгээх” товч дарна.

3-Р АЛХАМ:

“илгээх” товчийг дарснаар “Таны зөрүүтэй мэдээллийг шалгуулахаар ... дүүргийн /аймгийн/ улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ. Баярлалаа” гэдэг мэдээлэл гарч ирнэ. Ингэснээр Таны мэдээллийг бүртгэлийн байгууллага шалгаж, холбогдох хариуг өгөх юм.

4-Р АЛХАМ:

Түүнчлэн Та улсын бүртгэлийн байгууллагад биечлэн хандаж мэдээллээ засуулах боломжтой.



Илгээх



СОНГУУЛЬД ОРОЛЦОХ, НЭР ДЭВШҮҮЛЭХ

- Нам, эвслийг төлөөлж тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх намын салбар байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, орон нутгийн Хурлын сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө (2024.08.12-оос өмнө) тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ.
- Тухайн шатны сонгуулийн хороо нам, эвслийн сонгуульд оролцох тухай баримт, бичгийг хүлээн авснаас хойш 5 хоногт багтаан бүртгэх, эсэх шийдвэр гаргана.



НАМ, ЭВСЛЭЭС НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Нам, эвслээс нэр дэвшигчдийн баримт бичгийг нэр дэвшигч тус бүрээр дор дурдсан дарааллын дагуу бүрдүүлэн 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн дотор тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ.

/Баримтыг www.e-election.mn цахим системээр бүрдүүлэх боломжтой. Системд хэрэглэгчээр бүртгүүлэх болон холбогдох зааварчилгааг нам, эвслийн тухайн шатны сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтнаас авна уу./

1. Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт /31.2.1/

Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Маягтыг <https://m-election.mn/> цахим хуудсаас авах боломжтой./

2. Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл /31.2.2/

Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт. Маягтыг <https://m-election.mn/> цахим хуудсаас авах боломжтой./

3. Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар /31.2.7/

- <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Ерөнхий мэдээлэл" хэсгээс ХУР-с мэдээлэл дуудна.

-Иргэний үнэмлэхийг хуулбарыг <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулж болно.

4. Нэр дэвшигчийн намтар/31.2.6/

/Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт. Маягтын дагуу <https://www.e-election.mn/> системийн "Нэр дэвшигчийн бүртгэл"-ийг бөглөх./

5. Ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар; /31.2.3/

Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүн, Засгийн газраас байгуулсан төсөл, хөтөлбөрийн нэгж болон хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн бол 2024 оны 8 дугаар сарын

1-ний өдрөөс өмнө ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар

Шийдвэрийн хуулбарыг <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулна.

6. Хуулийн 28.3.1-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа; /31.2.4/

Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа /Лавлагааг дараах 3 төрлөөр авах боломжтой/

-<https://www.e-election.mn/> цахим системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шүүхийн лавлагаа" хэсгээс ХУР-с мэдээлэл дуудах.

-Төрийн үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn цахим системээс авах боломжтой.

-Нэр дэвшигчид олгох тодорхойлолтыг Шийдвэр гүйцэтгэх алба болон орон нутагт харьяа нэгжийн шийдвэр гүйцэтгэл хариуцсан газар, хэлтсээс, Улаанбаатар хотод Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо, ШШГЕГ-ын 2 дугаар байр. ШШГЕГ-ын лавлагааны утас 70001383, 70001480

7. Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт /31.2.5/

А.Нэр дэвшигч www.etax.mta.mn цахим хуудаст хандаж татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх тодорхойлолтыг авна.

Иргэн, хуулийн этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлснээр Цахим татварын системийн хэрэглэгч болж, татварын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болно.

Иймд иргэн www.etax.mta.mn цахим хуудаст хандан татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

/Бүртгүүлэх зааврыг Татварын ерөнхий газрын www.mta.mn цахим хуудаснаас авах боломжтой./

Б.Нэр дэвшигч аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол www.etax.mta.mn цахим

хуудаст хандаж байгууллагын татварын тодорхойлолтыг авна.

Тодорхойлолтыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан /захирал, нягтлан бодогч/ эсхүл нэр дэвшигч өөрөө цахим татварын системээс авах боломжтой.

/Тодорхойлолт авах дэлгэрэнгүй зааврыг Татварын ерөнхий газрын www.mta.mn цахим хуудаснаас авах боломжтой./

Лавлагаатай холбоотой асуудлаар 1800-1288 дугаар утсаар мэдээлэл авах боломжтой.

Лавлагааны хуулбарыг <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулна.

8. Ял эдэлж байгаа эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа /31.2.8/

-<https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Цагдаагийн лавлагаа" хэсгээс ХУР-с мэдээлэл дуудах.

-Эсхүл Төрийн үйлчилгээний нэгдсэн www.e-mongolia.mn цахим системээс авах боломжтой.

-Мөн ял эдэлж байгаа эсэх талаарх лавлагааг харьяа нутаг дэвсгэрийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Төрийн үйлчилгээний нэг цэг /Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбарууд/-ээс "Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт"-ын маягтаар авч болно.



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Бие даан нэр дэвшүүлэгч нь дор дурдсан дарааллын дагуу холбогдох баримтыг бүрдүүлэн 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн дотор тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ.

/Баримт бичгийг бүрдүүлэх зааварчилгаа Нам, эвслээс нэр дэвшигчийнхтэй адил/

1.Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар; /31.3.7/

2. Нэр дэвшигчийн намтар; /31.3.6/

3. Бие даан нэр дэвшигчийг төлөөлж сонгуулийн төв байгууллагатай харилцах хоёр хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харилцах утасны дугаар; /31.3.8/

4. Нэр дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл; /31.3.1/ /СЕХ-ны 2020-4-07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт. Маягтыг <https://m-election.mn/> цахим хуудаснаас авах боломжтой/

5. Сонгогчдын гарын үсэг зуруулсан маягт; 31.3.2.

/СЕХ-ны 2020-4-07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт.

Маягтыг 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тухайн шатны сонгуулийн хороодоос авна./

Маягтад тухайн сонгуулийн тойргийн дараах тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна:

– Аймаг, дүүргийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч 201-ээс доошгүй;

– Сумын Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч 51-ээс доошгүй.

/Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад тухайн нэр

/ЦЕГ-ын Лавлагааны сангийн 70191060, 70191089 дугаар утсаар лавлах боломжтой./

Лавлагааны хуулбарыг <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулна.

9. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг /31.2.9/

Мэдүүлгийн маягтыг www.m-election.mn цахим хуудсаас авах боломжтой.

/Мэдүүлгийн хуулбарыг <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулна./

10. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа /31.2.10/

Авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх лавлагааг тухайн нэр дэвшигч байгаа нутаг дэвсгэрийн цагдаа /аймаг, дүүрэг/-ийн газар, хэлтэст лавлагаа авах талаар хүсэлт гаргаж, албан бичгээр авна.

Лавлагааны сангийн 70191060, 70191089 дугаар утсаар лавлах боломжтой./

Лавлагааны хуулбарыг <https://www.e-election.mn/> системийн нэр дэвшигчийн бүртгэлийн "Шаардлагатай бичиг баримт хавсаргах" хэсэгт оруулна.

дэвшигчийг дэмжиж гарын үсэг зурж байгаа сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байх шаардлагатайг анхаарна уу/

Гарын үсэг зуруулах ажиллагааг e-election аппликэйшн ашиглан зохион байгуулах боломжтой.

6. Ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар; /31.3.3/

7. Хуулийн 28.3.1-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа; /31.3.4/

8. Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт. /31.3.5/

9. Хуульд заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт; /31.3.9/

10. Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа; /31.3.10/

11. Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг; /31.3.11/

12. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа. /31.3.12/

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ХЭН ХИЙХ ВЭ?

- Нам, эвслийн дарга, эсхүл түүний итгэмжлэл олгосон албан тушаалтан, ажилтан болон нэр дэвшигч, түүний менежер, шадар туслагч, ухуулагч (сонгууль эрхэлсэн байгууллага) сонгогчидтой уулзах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчлах зэрэг сонгуулийн сурталчилгааг хийнэ.
- Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ХИЙХ ХУГАЦАА

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс **24 ЦАГИЙН ӨМНӨ БУЮУ САНАЛ АВАХ ӨДРИЙН ӨМНӨХ ӨДРИЙН 00:00 ЦАГААС ӨМНӨ ЗОГСООНО. (2024.09.26-2024.10.09-ИЙГ ДУУСТАЛ).**



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛ

- Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй:
 - гурван хэвлэлийн хуудас сонин;
 - гурван хэвлэлийн хуудас сэтгүүл;
 - нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас.
- Нэг нам, эвслийн нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалаа нэгдмэл байдлаар хамтран гаргаж болно.
- Сурталчилгааны хэвлэмэл материалыг шуудангаар хүргүүлж болно.
- Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар, ухуулах хуудас байршуулахыг хориглоно.
- Нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг гэмтээх, устгахыг хориглоно.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ДАРААХ АРГА, ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛНА:

- ☑ Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- ☑ Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- ☑ Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;
- ☑ Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- ☑ Ухуулах байр ажиллуулах;
- ☑ Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;
- ☑ Цахим орчин ашиглах;
- ☑ Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.
- ☑ Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хандивын талаар сонгогчдод зар, урилга явуулсныг сурталчилгааны хэвлэмэл материалд оруулан тооцохгүй. Зар, урилга нь А5 хэмжээнээс илүүгүй байна.
- ☑ Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ

- Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны зорилгоор нэг хэсэгт хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно.
- Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан таних тэмдэггүй авто машин, автобус, мопед, мотоцикл болон бусад тээврийн хэрэгслийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно.
- Сонгуулийн сурталчилгаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгсэлд сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас, зурагт самбар, дэлгэц, уриа, намын далбаа, чанга яригч байрлуулж болно.



СОНГОГЧИДТОЙ УУЛЗАЛТ, ХУРАЛ, ЦУГЛААН ХИЙХ

- Сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглааныг сонгуулийн сурталчилгааны хугацаанд багтаан хийнэ.
- Уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.
- Шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллагаас бусад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд үнэ төлбөргүйгээр ашиглуулах үүрэгтэй.



УХУУЛАХ БАЙР АЖИЛЛУУЛАХ

- Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлах, танилцуулах, сурталчилгааны материал тараах, уулзалт, хурал цуглаан зохион байгуулах зорилгоор хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулж болно.
- Нэг нам, эвслээс нэр дэвшигчид хамтран нэг ухуулах байранд үйл ажиллагаа явуулж болно.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ЗУРАГТ САМБАР, ДЭЛГЭЦ АШИГЛАХ

- Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар, дэлгэц ашиглаж болно. Зурагт самбар, дэлгэц нь нэг хэсэгт 10-аас илүүгүй байна.
- Зурагт самбар, дэлгэц нь хоёр хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй, хөдөлгөөнт хэлбэртэй байж болох бөгөөд хэлбэр, загварт хязгаарлалт тавихгүй.
- Зурагт самбар, дэлгэцийг энэ хуулийн Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон байршилд үнэ төлбөргүй байрлуулна.
- Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.
- Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга, байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар, дэлгэц байрлуулахгүй.
- Нэг нам, эвслийн нэр дэвшигчид хамтран сурталчилгааны нэг самбар, дэлгэцтэй байж болох бөгөөд энэ тохиолдолд хариуцлагыг хамтран хүлээнэ.
- Зурагт самбар, дэлгэцэд тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг заавал дурдсан байна.
- Сонгуулийн сурталчилгааны хугацаанд гудамж талбайд байрлуулсан сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэцийг гэмтээх, устгахыг хориглоно.
- Зурагт самбар, дэлгэцийг байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчид аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.



РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ



Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлээр сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах талаарх зохицуулалт, баримтлах зарчим, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзахтай холбоотой харилцааг тодорхой зохицуулсан байдаг.

Сонгуулийн сурталчилгааг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-оос олгосон тусгай зөвшөөрөлтэй, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх бөгөөд радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуусталх хугацаанд Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах үүрэгтэй.


Харилцаа холбооны зохицуулах хорооноос сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдэл ирүүлэх боломжтой радио, телевизийн үндсэн сувгийн жагсаалтыг эзэмшлийн талаарх мэдээллийн хамт сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө гаргаж өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг дараах баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ. Үүнд:

1. СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛЭГ ЯВУУЛАХААР ТОГТООСОН НАРИЙВЧИЛСАН ЦАГИЙН ХУВААРЬ;
2. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЖИЛИЙН 1 ДҮГЭЭР САРЫН 1-НИЙ ӨДРӨӨС ӨМНӨХ ЖИЛИЙН 1 ДҮГЭЭР САРЫН 1-НИЙ ӨДРИЙГ ХҮРТЭЛХ ХУГАЦААНД ХИЙЖ БАЙСАН ГУРВААС ДООШГҮЙ ЗАР СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ГЭРЭЭ;
3. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ДУНДАЖ ҮНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ. (тухайн гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан үйлчилгээний үнэ тариф болон, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнийн саналыг хавсаргана)

Радио телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих зохицуулалтаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдлээ Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлж, бүртгүүлсэн радио, телевиз нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.9.2, 45.9.3-т заасан баримт бичгийг хүргүүлсэнд тооцох ба хуулийн 45.9.1-д заасны дагуу сурталчилгааны нэвтрүүлэг явуулахаар төлөвлөсөн цагийн хуваарийг хуульд заасан хугацаа дуусахаас өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлнэ.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.10-д Энэ хуулийн 45.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэхийг хориглоно.



Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчдэд үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх	Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй өдөр	Санал авах өдөр
2024 оны 09.26-10.09-ний өдрийн 23:59:59 цаг	2024 оны 10.10-11-ний өдрийг дуустал	2024 оны 10.11

Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн тухайд сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевиз нь хуулийн 38.4-т заасныг хангаагүй, сонгуулийн сурталчилгаа гэдгийг тодорхой илэрхийлээгүй, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй сонгуулийн сурталчилгааны болон сонгуулийн сурталчилгааны бус дараах нэвтрүүлэг нэвтрүүлсэн тохиолдолд **СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХУГАЦААНД** хамааруулж тооцно. Үүнд:

- Нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах, эх сурвалжийг дурдаагүй төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, реклам сурталчилгаа нэвтрүүлсэн бол;
- Эх сурвалжийг тодорхой дурдаагүй аливаа нэвтрүүлэгт улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс, нэрийг үзэгч, сонгогчдод сонгуулийн сурталчилгаа гэж ойлгогдохуйц байдлаар харуулах, дурдах, байршуулах, дууны үгэнд дурдсан бол;
- Сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс бичлэг, яриа нь орсон бол.

Олон нийтийн радио телевизээс бусад радио телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг (60 минут)-аас хэтрэхгүй байх ба сонгуулийн сурталчилгааны хоногт гарах нийт хугацааны хорин таван хувь (15 минут) нь нэг нам, эвсэл, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно.

Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглох бөгөөд нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй. Радио, телевиз нь өөрийн редакцад баримтлах бодлого, зохицуулалтын хүрээнд мэдээний таван минутын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 45.7-д заасан сонгуулийн сурталчилгаа, 45.14-т заасан мэдээ зэргийн хоногт гарах нийт хугацаанд тухайн сурталчилгааны нэвтрүүлэг, мэдээний давталт хамаарна.

Сонгуулийн талаарх дараах нэвтрүүлэг, сурталчилгаа нь **СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ХАМААРАХГҮЙ**. Үүнд:

- Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар болон сонгуулийн үйл явцын талаар радио, телевизийн өөрийн редакцад бэлтгэсэн мэдээ, сурвалжилга, тойм;
- Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа;
- Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг;
- Бүх шатны сонгуулийн байгууллагын албан ёсны мэдээ.

Радио телевиз нь сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагааг дуустал

сонгуулийн үйл явцын мэдээлэл, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа, бүх шатны сонгуулийн байгууллагын албан ёсны мэдээнээс бусад сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, сурвалжилга, тойм, эсхүл сонгуульд оролцогч нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон аливаа нэвтрүүлэг, мэтгэлцээн, хөтөлбөр, дуу, ярилцлагыг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.17-д заасны дагуу улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр нэвтрүүлэхдээ оролцогчдод адил асуулт тавих, хариултын адил хугацаа тогтоох, талуудаас адил тооны хүн оролцуулах зэрэг мэтгэлцээний тогтсон дэгтэй байх ба оролцсон нам, эвсэл, бие даагч болон нэр дэвшигчдийн нэрийг намын харьяаллын хамт тодорхой илэрхийлсэн байна.

Телевиз нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1,11.2.4-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл болон улс төрийн мэтгэлцээн бэлтгэн хүргэхдээ хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай гаргана.

Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар



ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ

• Бүртгэл:

- Нэр дэвшигч: **2024.09.26-наас 2024.09.28-ыг** дуустал аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд
- Бусад цахим хуудас **2024.09.29-нөөс** өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд

• Сурталчилгаа: 2024.09.26-наас 2024.10.09-нийг дуустал

- (46.3. Хуулийн 46.1.1, 46.1.3-т заасан цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ.)
- “Хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн” гэх таних тэмдгийг харагдахуйц байдлаар байрлуулах

! Хяналт: Тагнуул, Цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч

• Сурталчилгаа зогсоох: Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс **24** цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн **00:00** цагаас өмнө зогсооно.

! Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаанд ашигласан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд түр хязгаарлах буюу сонгогчдод харагдахгүй болгох технологийн арга хэмжээ авах.

• Зардал: Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал нь сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээний **15 хувиас** хэтрэхгүй байна.

Зөрчлийн харьяалал

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл. Сонгуулийн хуулийг зөрчих 13, 14, 15, 16, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил	Харьяалал
Сонгуулийн сурталчилгаанд хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
Үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаагаагүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	харилцаа холбооны хяналтын улсын байцаагч
Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийсэн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч
Харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	ШӨХТГазрын улсын хяналтын байцаагч

Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг бүртгүүлэх

Цахим хуудас	Тайлбар	Бүртгэл
нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас	Нэр дэвшигчийн, нам эвслийн вэбсайт	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо
цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас;	Нам эвсэл, нэр дэвшигчийн олон нийтийн сүлжээний цахим хуудаснууд /пэйж хуудас, профайл/	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо
бусад цахим хуудас	Бусад вэбсайт	Харилцаа холбооны зохицуулах хороо

ХХЗХ-ны Зохицуулалтын газар


 СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЯВЦАД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- ☒ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;
- ☒ Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;
- ☒ Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
- ☒ Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
- ☒ Оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;
- ☒ Олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.



- Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэхийг хориглоно.
- Сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор тэдгээрийн нэрийн өмнөөс аливаа этгээд санаатайгаар хууль бус сурталчилгаа хийхийг хориглоно.
- Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ХИЙХ, СОНГОГЧДЫН САНАЛЫГ ТАТАХ зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг **ХОРИГЛОНО**



Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүйгээр үзүүлэх;



Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх;



Сонгогчийг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах;



Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх;



Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;



Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх.

Хэрвээ хуульд заасан хориглох үйлдэл, үйл ажиллагаа гарсан тохиолдолд сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно. Ингэснээр хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг АРАВ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.



-Орон нутгийн Хурлын ээлжит сонгууль 10 дугаар сарын 11-нд болно. Сонгогчдын хувьд энэ удаагийн сонгууль хэр чухал вэ?

-Саяхан сонгууль болоод дуусаж байхад одоо бас юун сонгууль вэ гэж гайхах хүмүүстэй таарч байна л даа. Бид өнгөрсөн зургаадугаар сард хууль тогтоох байгууллага буюу Улсын Их Хурлаа сонгож байгуулсан. Удахгүй Улсын Их Хурлын сонгуулиас ч илүү чухал сонгууль болох орон нутгийн Хурлаа өөрсдөө сонгож байгуулах нь. Бид УИХ-ын, мөн Ерөнхийлөгчийн сонгуульд илүү оролцоотой байдаг, магадгүй энэ нь үндэсний түвшний сонгуультай холбоотой байж болно. Гэхдээ эдгээр сонгуулиас дутуугүй, бүр илүү чухал хариуцлагатай сонгууль болох орон нутгийн сонгуульд сонгогчид бага ач холбогдол өгдөг юм шиг санагддаг.

-Ач холбогдол өгдөггүй гэдгийг та илүү сонгогчдын ирц оролцоотой холбоотой хэлж байна уу?

-Нэг талаас сонгогчдын ирцтэй холбож ингэж хэлж байна. Тухайлбал, орон нутгийн сонгуулийн ирц 2008 онд 59, 2012 онд 53, 2016 онд 60, 2020 онд 56 хувь байсан. Сонгууль тус бүрийн хувьд хэдхэн сарын өмнө болж өнгөрдөг Улсын Их Хурлын сонгуулиас дандаа ирц буурч байгаа нь ажиглагддаг.

Нөгөө талаас орон нутгийн сонгуулийн үр дүнд байгуулагддаг Иргэдийн төлөөлөгчдийн хурал гэдэг Монгол Улсын Үндсэн хуульд заасан нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдэл, чиг үүрэг, онцлогийг сайн мэдэхгүйтэй холбоотой болов уу гэж боддог. Иргэдийн олонх нь эргэн тойрны бүхий л асуудлаа Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд шийдэж өгнө гэж боддог. Гэтэл тийм биш шүү дээ, Тайван сайхан амьдрахыг, залуу насаа түгжрэлд өнгөрүүлэхийг хүсэхгүй байгаа бол, хамгийн ойроос хамгийн чанартай эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авмаар байгаа бол, харанхуй биш гэрэлтэй

С.ОЮУНТУЯА: АМЬДРАЛД ОЙРХОН ШИЙДВЭР ГАРГАХ ХҮМҮҮСИЙГ СОНГОНО ГЭДЭГ УТГААР ХАРИУЦЛАГАТАЙ ХАНДААРАЙ

*“Сонгогчдын боловсрол” төвийн
Гүйцэтгэх захирал С.Оюунтуяатай
ярилцлаа.*

гудамжтай байхыг хүсвэл, хүүхдүүддээ эрүүл аюулгүй орчин бүрдүүлж өгье гэвэл орон нутгийн сонгуульдаа л идэвхтэй оролцох ёстой юм, уг нь.

-Амьдралд, амьдрах орчин хамгийн ойр шийдвэр гаргадаг хүмүүсээ сонгох сонгууль гэж ойлгож болох нь ээ.

-Тэгэхээр орон нутгийн хурлын сонгууль бол тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгтээ буюу тухайн нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд өөрсдийн амьдралын тулгамдсан аливаа асуудлыг өөрсдөө шийдвэрлэж, өөрсдөө хариуцах боломж олгодог учраас иргэдэд хамгийн ойрхон, хамгийн чухал, хамгийн хариуцлагатай сонгууль гэж хэлж болно. Харин бидний сонгож байгуулдаг Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь өөрийн нутаг дэвсгэртээ нийтийг хамарсан дүрэм журам тогтоох, эдийн засаг, нийгэм, соёлын гээд олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг, эрх мэдэл бүхий иргэд сонгогч бидэнд ойрхон, өдөр тутмын амьдралд холбоотой бодлого, шийдвэрт оролцох боломж олгодог байгууллага юм. Өөрөөр хэлбэл, иргэдэд хамгийн ойр, өдөр тутмын амьдралтай нь салшгүй холбоотой, эргэн тойронд тулгамдаад байгаа асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэдэг хүмүүс. Тухайлбал, ямар нийтийн тээвэртэй байх, амьдарч буй байрны гаднах талбай нь эрүүл, аюулгүй, тохижилттой байх, хүүхэд залуус чөлөөт цагаа өнгөрөөх, хөгжих боломжтой орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэж, түүнийг шийдвэрлэх, төлөөлөх хүмүүсийг сонгодог.

-Сонгогчдод хандаж юу захиx вэ?

-Миний амьдралд хамгийн ойрхон шийдвэр гаргах, надтай хамгийн ойр ажиллах хүмүүсийг сонгож байна гэдэг утгаар хариуцлагатай хандаарай. Манайд, надад хамааралтай ямар ажил хийх үү, амьдрах орчин, нөхцөлийг яаж сайжруулах уу гэдэг талаас нь мөрийн хөтөлбөртэй нь маш сайн танилцах ёстой. Мөрийн хөтөлбөртэй нь танилцаж шийдвэрээ гаргаад сонгуульдаа заавал оролцоорой гэж захимаар байна.

САНАЛЫН ХУУДАС

Саналын хуудас сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүн гаргах үндсэн баримт бичиг юм.

САНАЛЫН ХУУДАС НЬ:

- Агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчоос саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой;
- Сонгогч саналаа тэмдэглэх тухай заавар агуулсан.
- Саналын хуудаст нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийнх нь нэрийг том үсгээр бичих ба нам, эвсэл нэр дэвшүүлсэн бол тухайн нам, эвслийн нэрийг бичнэ.
- Саналын хуудас тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.

САНАЛЫН ХУУДАСТ НЭР ДЭВШИГЧИЙН НЭРИЙГ БИЧИХ ДАРААЛАЛ

- Намын нэрийг Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар;
- Эвслийн нэрийг тухайн эвсэлд нэгдэн орсон намуудаас хамгийн түрүүнд улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар;
- Нам, эвслээс нэр дэвшигчийг тухайн нам, эвслээс ирүүлсэн дарааллаар;
- Бие даан нэр дэвшигчийг сонгуулийн хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан нам, эвслээс нэр дэвшигчийн нэрийн дараа.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн
283 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

САНАЛЫН ХУУДАС

..... аймаг, сум, р баг
..... дугаар хэсэг

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

Та өөрийн сонгохыг хүссэн ... нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будах саналаа тэмдэглэнэ үү. ...с илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцож анхаарна уу.

Нэм. 1	Нэм. 2	Бие даан нэр дэвшсэн
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

Та өөрийн сонгохыг хүссэн ... нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будах саналаа тэмдэглэнэ үү. ...с илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцож анхаарна уу.

Нэм. 1	Нэм. 2	Бие даан нэр дэвшсэн
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР

- Саналын хуудаст бичигдэх нам, эвслийн нэр, нэр дэвшигчийн өөрийн болон эцэг, эхийн нэрийн үнэн зөв эсэхийг бүртгэсэн сонгуулийн хороо нь хариуцна.

САНАЛЫН ХУУДСЫГ ХЭВЛҮҮЛЭХ, ХҮРГҮҮЛЭХ

- Саналын хуудсыг үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрөлтэй, тагнуулын байгууллагаас олгосон аж ахуйн нэгж хэвлэх бөгөөд саналын хуудас нь Сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжид ашиглагдах тусгай шаардлага хангасан байна.
- Сонгуулийн ерөнхий хороо улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сонгогчийн тоонд үндэслэн саналын хуудасны тоо, загварыг баталж, хэвлүүлдэг.
- Саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх үйл ажиллагааны хамгаалалтыг цагдаагийн байгууллага, төрийн тусгай хамгаалалтын асуудал хариуцсан байгууллага хариуцах бөгөөд тагнуулын асуудал хариуцсан байгууллага хяналт тавьж ажиллана.
- Нам, эвсэл, төрийн бус байгууллагын төлөөлөл саналын хуудас хэвлүүлэх үйл ажиллагааг ажиглаж болно.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 2 дугаар сарын 11-ны өдрийн
283 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

САНАЛЫН ХУУДАС

..... дүүрэг, 28-р хороо
..... дугаар хэсэг

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

Та өөрийн сонгохыг хүссэн ... нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будах саналаа тэмдэглэнэ үү. ...с илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцож анхаарна уу.

Нэм. 1	Нэм. 2	Бие даан нэр дэвшсэн
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

Та өөрийн сонгохыг хүссэн ... нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг дүүргэн будах саналаа тэмдэглэнэ үү. ...с илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцож анхаарна уу.

Нэм. 1	Нэм. 2	Бие даан нэр дэвшсэн
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР
☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР	☐ Цэцэгтэгийн нэр НЭР

**Орон нутгийн Хурлын 2020 оны ээлжит
сонгуулийн саналын хуудасны загвар**

ЗӨӨВРИЙН ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ

Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР 09.00-20.00 ЦАГТ САНАЛ АВНА.

- Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч;
- Нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа сонгогч;
- Зөрчлийн улмаас саатуулагдсан, баривчлагдсан сонгогч;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогчийн хүсэлт, эмнэлгийн магадалгаа эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтын үндэслэн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авна.

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн хэсгийн хорооны даргын баталсан хуваарь, чиглэлийн дагуу оршин суугаа газарт нь очиж авна.

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн иргэний үнэмлэхийг нь шалгасны үндсэн дээр саналын хуудас олгоно.

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаанд өөр өөр нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн төлөөлөл бүхий хоёроос доошгүй ажиглагчийг оролцуулж болно.

-ЗӨӨВРИЙН БИТҮҮМЖИЛСЭН САНАЛЫН ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ ХҮСЭЛТЭЭ ХААНА, ХЭЗЭЭ ГАРГАХ ВЭ?

-Сонгогч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтээ тухайн байгууллагын удирдлагад өгөх бөгөөд байгууллагын удирдлага уг хүсэлтийг байгууллагын тодорхойлолтын хамт санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ. Түүнчлэн Эрүүл мэндийн байдлын улмаас зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх харьяа өрхийн эмчийн магадалгаа, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ. Тухайн сонгогч асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол тухайн сонгогчийн харьяалагдах баг, хорооны Засаг дарга түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх үүрэгтэй.




СОНГОГЧ САНАЛАА ХЭРХЭН ӨГӨХ ВЭ?

Сонгуулийн санал авах өдөр бүх нийтээр амрах өдөр байдаг. Хэрвээ сонгуулийн санал авах өдөр ажиллаж байгаа сонгогч байвал байгууллагынх нь захиргаа чөлөө олгож, саналаа өгөх боломжоор хангах үүрэг хүлээдэг. сонгуулийн санал авах өдөр саналаа өгөх боломжгүй зарим сонгогчдын саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авдаг тусгай журам бий. Тухайлбал, эрүүл мэндийн байдлын улмаас санал авах өдөр санал авах байранд биечлэн очиж саналаа өгөх боломжгүй сонгогч сонгуулийн хэсгийн хороонд хуульд заасан журмын дагуу хүсэлт гаргаж саналаа өгөх боломжтой.

САНАЛ АВАХ БАЙРАНД ОЧИЖ, САНАЛАА ӨГӨХ

Санал авах байранд иргэний үнэмлэхтэй ирж, саналаа биечлэн өгөх бөгөөд сонгогч саналын хуудсанд бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө. Гарын хурууны хээгээр нь сонгогчийг баталгаажуулж, саналын хуудас олгох бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна. Хэрэв гарын хурууны хээгээр нь сонгогчийг таних боломжгүй бол сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган



шалгаж, сонгогчийн бүртгэлийн хуудас олгох юм.

Сонгогч санал бэлтгэх бүхээгт нууцаар саналаа тэмдэглэнэ. Сонгогч иргэн саналаа тэмдэглэхдээ та өөрийн нутаг дэвсгэр дэх тойрогт ногдсон мандатын тоотой тэнцүү дугуй дугуйлна.

Хэсгийн хорооны дарга, гишүүд болон холбогдох бусад этгээд сонгогчийн саналын нууцлалыг алдагдуулахыг хориглодог. Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтас хэрэглэж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийнэ. Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж, буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийхээс өмнөнэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа өгч болно. Мөн санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй бол сонгогч энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, уг саналын хуудсыг хураалгаж, дахин саналын хуудас авч, саналаа өгч болно. Санал авах өдрийн 20:00 цагт сонгогчийн бүртгэл зогсох бөгөөд бүртгэлийн хуудсаа 20:00 цагаас өмнө авсан бол сонгогч саналаа өгөх боломжтой.

Санал авах байрыг бэлтгэхдээ харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, санал тэмдэглэх зориулалттай брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байхаар зохицуулсан. Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож, бэлтгэсэн байх шаардлагатай. Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна. Түүнчлэн санал авах байранд хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй

илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулна. Эдгээр зохицуулалт нь сонгогчийн саналаа нууцаар өгөх боломжийг хангах юм.

Сонгогч зайлшгүй мэдэх бас нэг чухал зүйл бол саналын хуудас. Саналын хуудас нь сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүн гаргах үндсэн баримт бичиг болдог. Өөрөөр хэлбэл, саналын хуудас нь сонгогчид өгч саналыг тэмдэглүүлээд, саналын хайрцагт хийлгүүлээд, түүнийг нь тоолоод хэн ялсныг нь тооцдог, сонгуулийн дараа тодорхой хугацаагаар хадгалдаг чухал баримт бичиг юм. Саналын хуудас нь агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчоос саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх бөгөөд саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар агуулсан байдаг. Тиймээс саналын хуудсанд тэмдэглэл

Аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн санал авах байранд санал авах ажиллагаа 2024 оны 10 дугаар сарын 11-ий өдөр Улаанбаатарын цагаар 07:00- 20:00 цаг хүртэл хугацаанд явагдана.

СОНГОГЧИЙН САНАЛАА ӨГӨХ ЯВЦЫН ДАРААЛАЛ:

- Иргэний бүртгэлийн итгэмжилсэн ажилтан сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээг тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулган үзэж, **зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.**
- Хэсгийн хорооны гишүүнд сонгогчийн бүртгэлийн хуудсыг өгч **саналын хуудас хүлээн авна.**
- Саналын хуудас аваад **сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зурна.**
- Санал бэлтгэх бүхээгт очиж, саналын хуудаст бичигдсэн **зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.**

Саналаа өгөхдөө өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн өмнөх дугуйг тусгай тэмдэглэгээний үзэг ашиглан дүүргэн будаж тэмдэглэнэ.

Тойрогт ногдох мандатын тооноос илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцох тул санал тэмдэглэх заавраа сайтар уншаарай.

- Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах **зориулалт бүхий хавтсанд саналын хуудсаа хийнэ.**
- Энэхүү саналын хуудсаа **санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийнэ.**

хийхийн өмнө энэ заавартай сайтар, нямбай танилцаж, ямар нэг алдаа мадаггүй саналаа өгөх боломжтой.

Батлагдсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудас нь хүчингүй байх бөгөөд хүчингүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглодог юм шүү. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглодог.

Сонгогч Та Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх, эрх чөлөөгөө эдэлж, сонгуульд идэвхтэй оролцон саналаа өгөөрэй.

Сонгогч санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг уншуулаад **САНАЛЫН ХУУДАС АМЖИЛТТАЙ УНШИГДЛАА** гэсэн бичиг гартал түр хүлээх шаардлагатай.

СОНГОГЧ САНАЛАА ӨГӨХДӨӨ ДАРААХ ҮЙЛДЛИЙГ ХИЙХИЙГ ХОРИГЛОДОГ.



Санал авах байранд санал өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх;



Өөр хүний бичиг баримт, хуурамч баримт бичиг ашиглаж санал өгөх, саналаа өгөхийг оролдох;



Хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудас ашиглах;



Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, эсвэл авч гарах;



Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах үйлдэл хийх;




Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах, зориулалтын бус үзгээр санал тэмдэглэх;



Аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсвэл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ БОЛ ИРГЭД, ЗАЛУУС ОРОЛЦООГОО ХАНГАХ, ТӨСӨВТ ОРОЛЦОХ, ЗАСАГЛАЛД ХЯНАЛТ ТАВИХ ХАМГИЙН ОЙРХОН БОЛОМЖ



Лийд төгсөгчдийн холбооны гишүүн П.ЭНХМАА

Залуус орон нутагтаа тулгамдаж буй асуудлуудыг илрүүлж, нэгдэж шийдэл хайх, орон нутгийн засаг захиргаанд шаардлага хүргүүлэх буюу улс төрийн оролцоогоо бэхжүүлэх нь чухал. Нийгмийн эгэх хариуцлагын чиглэлээр төвлөрөн ажилладаг Өвөрхангай аймгийн "Иргэдийн засаглал" ТББ-ын тэргүүн Б.Ууганхүү "Сонгууль бол залуусын оролцоог илэрхийлэх чухал хэлбэр. Ялангуяа орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол иргэд, залуус оролцоогоо хангах, төсөвт оролцох, засаглалд хяналт тавих хамгийн ойрхон боломж" хэмээн залуусын улс төрийн оролцооны талаар үзэл бодлоо хуваалцсан.

"Зам засмаар байна", "Гэрэлтүүлэг муу байна", "Бэлчээрийн усан хангамжийг сайжруулъя" гэсэн иргэдийн шаардлагыг ажил хэрэг болгох үүрэг эрх, мэдлийг аймаг, дүүрэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийддэг. Тодруулбал иргэдийн өдөр тутмын ажил, амьдралд нөлөөлөх шийдвэрийг шат шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд гаргадаг. Тиймээс үл хайхарч болохгүй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ес дэх удаагийн сонгууль 2024 оны 10 дугаар сарын 11-нд улс орон даяар зохион байгуулагдана. Аливаа сонгуульд ирц муутай, идэвхгүй насныхан бол 15-34 насныхан. 18-34 насныхны хувьд Орон нутгийн сонгуульд 2016 онд 32,6 хувь, 2020 онд 37,4 хувийн ирцтэй оролцож байсан. Харин УИХ сонгуулийн хувьд 50-аас дээш хувийн ирцтэй оролцож байна.

Залуучууд сонгуульд оролцохгүй байна гэж шүүмжилдэг. Харин залуучууд болохоор сонгогчид хүн, дэмжмээр бодлого байхгүй байна

гэдэг. Залуус сонгуулийн оролцоо сул байгаагаа тэдэнд зориулсан бодлого үйл ажиллагаа намуудын мөрийн хөтөлбөрт хангалттай тусгаагүйтэй холбож буй болсудлаачдын зүгээс намууд саналөгч буй насны бүлгийнхэнд зориулсан хөтөлбөр боловсруулдаг. Тиймээс залуус сонгуулийн оролцоогоо нэмснээр намуудын мөрийн хөтөлбөрт залууст зориулсан хөтөлбөр, үйл ажиллагаа нэмэгдэнэ гэж зөвлөдөг.

Залуусын сонгуулийн оролцоог нэмэх өөр нэг боломж нь залуу нэр дэвшигчдийг олноор нэр дэвшүүлэх байдаг. 2020-2024 оны шат шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийт 7346 төлөөлөгч Монгол Улсын хэмжээнд сонгогдон ажиллаж байна. Эдгээрийн 26,2 хувь нь 18-34 насны залуус сонгогджээ. Монгол Улсад эл насны сая иргэн бий. 2024 оны 10 дугаар сарын 11-нд Монгол Улсын хэмжээнд шат, шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын нийт 8028 төлөөлөгчийг сонгоно.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийн байгууллага учраас 18 нас хүрсэн, ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох зэргээр эдийн засгийн эрх мэдэл нь нэмэгдсэн.

СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НЬ ҮҮРЭГ БИЕЛҮҮЛЭХ БИШ ЭРХЭЭ ЭДЭЛЖ БАЙГАА ХЭРЭГ



UnFilter podcast

Иргэний боловсролыг дэмэлнэ

С.Энэрэл-Сэтгүүлч

Б.Анхзаяа - Улс төр судлалын
магистр



Улс төрийн боловсрол олгох “UnFilter” подкастыг эрхлэн гаргагчдын зүгээс иргэд, уншигчдад зориулан цуврал захидал илгээдэг. Энэ удаад орон нутгийн сонгуульд яагаад бид анхааран оролцох ёстой талаар тэд ийн бичжээ.

...Хүмүүс нэгэндээ захиа бичих сайхан. Сэтгэлээ шингээсэн, сэтгэл нь нэвт үнэртсэн, бас мэдлэг мэдээлэл өгөх тийм нэг захидал уншаад сууж байхад сайхан байдаг шүү дээ. Иргэдэд улс төрийн боловсрол олгох сувгаа нээгээд багагүй хугацаа өнгөрлөө. Энэ удаад ирэх аравдугаар сарын 11-нд болох орон нутгийн сонгууль яагаад чухал талаар онцлон дурдахыг хүсэж байна. Монголчууд бидний хувьд түүхэн жил өнгөрөх гэж байна. Хууль тогтоох байгууллагад өөрсдийнхөө төлөөлөл болгож 126 хүнийг илгээлээ. Таалагдсан, таалагдаагүй. Зөвдсөн буруутсан аль нь ч гэж хүмүүс үзэж байгаа хамаарал үгүйгээр бид хүчин төгөлдөр хуулийнхаа хүрээнд ардчилсан зарчмаар, элдэв зөрчил маргаангүйгээр саналаа өгч, төр засгаа байгуулав. Хэрэв сонгуулийн үр дүнд сэтгэл дундуур байвал дараа нь биш өмнө нь оролцоогоороо засах боломж бидэнд бас бий.

Бид сонгуульд оролцохыг үүргээ биелүүлэх явдал гээд ойлгоод байдаг. Хүн гэдэг амьтан заримдаа үүргээс татгалзчих гээд байдаг гэмтэй. Гэхдээ сонгуульд оролцох нь үүрэг гэхээсээ эрхээ эдэлж

байна гээд ойлгох нь илүү дээр. Угаасаа Үндсэн хуульд заасан сонгох, сонгогдох эрхээ сонгуулиар та эдэлж байгаа хэрэг шүү дээ. Бас төр засгийн, нийслэл аймаг сумын шийдвэр гаргах ажлуудад өөрийгөө төлөөлж ажиллах хүнийг сонгож байгаа учраас угаасаа энэ бол үүргийн биш эрхийн тухай асуудал юм. Хэрэв та сонгуульд оролцохгүй байна гэвэл энэ эрхээ хэн нэгэнд шилжүүлээд өгчхөж байгаа хэрэг.

Хүүхдүүдийн сургууль, цэцэрлэг таны ойр биш, хог асуудалтай, амьдрах орчны зам харгуй чинь муу, байж байгаад л боржур сольдогт бухимдал чинь төрдөг бол ер нь юу эс байх вэ дээ олон шийдмээр асуудал байдаг бол та түүнийг өөрөө очоод хийдэггүй юм гэхэд таны өмнөөс хийе гээд нэр дэвшиж байгаа хүмүүсээс зөвийг нь сонгочих хэрэгтэй юм. Тэр зөв гэж бодсон хүнээ сонгохын тулд санал өгөх өдөр эрт нь үгүй юм гэхэд цагтаа амжиж очоод саналаа өгчихдөг байх хэрэгтэй билээ. Энэ бол та оролцоогоороо эрхээ эдэлж байгаа хэрэг. Тэгээгүй байж араас нь юу ч ярьсан ямар ч үнэ цэнгүй.

Судалгаанаас харахад монголчуудын илүүд үздэг улс төрийн оролцооны хэлбэр төс засгийн байгууллагад санал хүсэлтээ тавих 52.5, радио телевиз, сонин хэвлэлд хандах 13.7, нас эвсэл хөдөлгөөнд нэгдэх 8.4, ажил хаялт, жагсаалд оролцох 7.1, өлсгөлөн зарлах 2.7 хувь байдаг гэж гарсан байдаг. Уг нь сонгуульдаа идэвхтэй оролцож, төлөөллөө сонгож, түүгээрээ оролцоогоо хангах ёстой ч бид үүн дээр жаахан хойрго хандсаар ирлээ.

Ялангуяа орон нутгийн сонгуульд бүр хойш суумтгай. УИХ-ын сонгууль гэж хаваржин бужигнаж

бужигнаж, сонгуулийн үр дүн таалагдсан, эс таалагдсантай холбоотой байдаг юм уу, сонгуулиас сонгуулийн хооронд ирц буурсаар ирсэн байдаг.

Гэхдээ иргэд бидний хамгийн их ярьдаг, хамгийн их асуудалтай гэдэг зүйлсийг шийдэх хүмүүсээ яг энэ хоёр шатны иргэдийн төлөөлөгчдийг сонгох сонгуулиар гаргадаг шүү гэдгийг дахин дахин хэлмээр байна. Нийслэл дүүрэг, аймаг, сумдын иргэдийн хурлын төлөөлөгчдөө сонгож, энэ сонголтоороо та эрхээ эдэлж чадна шүү. УИХ-ын гишүүн, Иргэдийн хурлын төлөөлөгчдийн хийх ажлын эрх үүргийн ялгааг ялгаж салгахгүй хүмүүс олон. УИХ-ын гишүүн хууль тогтоож, хуулийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй, харин яг гэрийн хажуугийн зам, хүүхдийн сургууль цэцэрлэг гээд өдөр тутамдаа хэрэг болдог ажлыг хийдэг хүмүүсийг ирэх аравдугаар сард болох Орон нутгийн сонгуулиар тодруулах учраас хэн иргэдтэйгээ ойр ажиллах ёстой тэр хүмүүсээ гаргах нь бидний хэтэд дэмтэй юм. Сонгууль болохоос хоёр сарын өмнө шилжилт хөдөлгөөн зогсооно гээд зарлаад байхад анзаарахгүй байж байгаад гэнэт хороон дээрээ очоод уурлаад эхэлдэг гэм бий шүү, бидэнд.

Өнөө жилийн хувьд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль 2020 онд батлагдсан хуулиараа явагдана. Уг нь энэ хуулийг УИХ-ын сонгуулийн хууль нэлээд өөрчлөгдөж, жагсаалтаар тодорхой хувийн гишүүдийг оруулсан шиг холимог тогтолцоогоор явагдан, нэг хүйсийн нэр дэвшигчид байх доод хэмжээ 20 биш ядаж 30 хувь руу орж ирэх, ухуулагчдын тоо хэмжээг ч цөөлнө гэсэн хүлээлт байсан ч өнгөрсөн намар сонгууль болохоос жилийн өмнө батлах хуулийн хугацаагаа өнгөрүүлчихсэн учраас өмнөх хуулиараа зохион байгуулагдаж таарна. Хууль хуучнаараа явах тусам сонгогч бидний хувьд илүү мэдрэмжтэй байх шаардлага гарна аа гэсэн үг.

Мэдээж өнгөрсөн орон нутгийн сонгуулиар хэрэгжиж эхэлсэн 25 нас хүрсэн хүн нэр дэвших эрхтэй байдаг байсан нь 18 нас болж өөрчлөгдсөн нь хэвээр үйлчилнэ. Залуучууд та нар маань хотынхоо, сум, дүүрэг, аймгийнхаа хөгжилд гар бие оролцох боломж санал өгөх эрхтэй чинь адил нээлттэй байгаа гэдгийг битгий мартаарай. Бүх насны, бүх хүйсийн, нийгмийн бүлгийн төлөөлөл бүрийн оролцоо их байх тусам бид амьдарч байгаа орчноо илүү сайхан болгож чадна.

Дөрвөн жилийн өмнөх сонгуульд 8169 суудлын төлөө 17161 хүн нэр дэвшин өрсөлдөж байсан юм билээ. Өнөө жилийн хувьд энэ тоо нэмэгдэх магадлалтайг судлаачид онцолж байгаа. Өөрөөр хэлбэл, оролцоо улам бүр нэмэгдэж байна л гэсэн үг. Гэтэл та, хэн нэгэн хүнийг “чадах” гэж байгаа мэт “Яршиг, тэр сонгуульд нь оролцохгүй ээ” гээд сууж байгаа юм биш биз. 1992 оноос хойш сонгуулийн ирц сонгуулиас сонгуульд буурч байсан үе бий. Ялангуяа орон нутгийн сонгууль дээр. 2012 онд зарим аймаг, дүүрэгт ирц хүрээгүйгээс дахин сонгууль зарласан ч удаатай. Гэхдээ одоо ирц хамаарахгүй болсон. Өөрөөр хэлбэл, босго байхгүй. Хэдэн хүн санал өгсөн түүгээр хүчин төгөлдөр тооцогдоно. Тэгэхээр та санал хураалтад оролцохгүй байснаараа хэн нэгнийг



чадаж байгаа биш таны санал, оролцоогүйгээр бүх зүйл явна аа гэдгийг л ойлгочих хэрэгтэй. Дараа нь ийм ч нам гарахгүй байсан, ийм ч хүн гарахгүй байсан, ийм ч ажил хийсэнгүй гээд гомдоллоод нэмэргүй. Та өөрийнхөө хүсэлтээр тойргоос гарсан шүү дээ.

Нөгөө талаас сонгогч хүн үнэ цэнтэй сонгогч байхыг хүсдэг. Өөрөөр хэлбэл, хэн гэдэг нэр дэвшигч олны санал авч сонгогдчих гээд байгааг ажиглаж байгаад саналаа өгдөг. Миний санал өгсөн хүн сонгогджээ гэх нь сайхан санагддаг гэсэн үг л дээ. Харин үүнийхээ оронд нэр дэвшигч нараа илүү судлаарай гэж зөвлөмөөр байна. Жинхэнэ газар дээр тулж ажиллах хүмүүсээ сонгох гээд байна шүү дээ.

Сонгуульд оролцсоноор таны хэн нэгний өмнө хүлээсэн үүрэг биелүүлээд байгаа биш шүү. Харин та Монгол Улсын иргэнийхээ хувьд эрхээ эдэлж байна. Эрх эдлэхэд дургүй хүн байдаг бил үү. Ирж эрхээ эдлэх өдөр чинь 2024 оны аравдугаар сарын 11 шүү.

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ.

**“UnFilter” подкастыг эрхлэн гаргагч Э.ЭНЭРЭЛ,
Б.АНХЗАЯА**

СОНГУУЛИЙН АЖИГЛАЛТ



ажиглагчаар ажиллах бөгөөд харин нэр дэвшигч болон төрийн албан хаагчдыг ажиглагчаар ажиллахыг хориглодог.

Ажиглагч нь сонгуулийн бүхий л үе шатанд шударга байдлыг эрхэмлэх ба санал авах ажиллагааг ажиглах үедээ улс төрийн нам, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн хандлага бүхий аливаа үйлдэл үйл ажиллагаа, зохион байгуулахгүй, оролцохгүй байх, сонгуульд оролцож буй нам, эвсэл нэр дэвшигчийн сонгуулийн уриа, нэр, туг далбаа, бэлгэ тэмдэг, тэдгээрийн өнгө бүхий хувцас хэрэглэл хэрэглэхгүй.

Ажиглагч нь санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглах бөгөөд дараах эрх эдэлнэ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль эрх тэгш, ил тод, шударга, хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхэд улс төрийн нам, эвсэл, төрийн бус байгууллага, гадаадын болон олон улсын ажиглагч гадаадын улсын иргэд сонгуулийн хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд сонгуулийн ажиглалт хийдэг.

Сонгуулийн ажиглалт нь сонгуулийн үйл ажиллагаа хууль тогтоомжид заасны дагуу ил тод, шударга явагдсан эсэх, сонгуулийн албан ёсны дүн үнэн бодитой гарсны баталгаа болдог.

Сонгуулийн ажиглалтын гол зорилго нь сонгуулийн санал хураалтын үйл явц сонгогчдын эрхийг хангах нөхцөлийг хангаж буй эсэх, мөн болзошгүй алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонгуульд оролцогч талууд ялангуяа сонгогчид үнэн бодит мэдээллээр хангагдах, тэдний итгэл найдварыг бэхжүүлж, тэдний идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу улс төрийн нам, эвсэл, эсхүл нэр, дэвшигч төрийн үйл хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага болон гадаадын болон олон улсын байгууллага, гадаад улсын иргэн сонгуулийг ажиллах эрхтэй.

Нам, эвсэл эсхүл нэр дэвшигч нь нэг санал авах байранд 3 хүртэл, төрийн бус байгууллага 2 хүртэл ажиглагчийг томилж ажиллуулна. 18 насанд хүрсэн эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сонгуулийн

- Саналын хуудасны битүүмжлэгдсэн байдал болон зарцуулалтын тайлантай танилцах;
- Санал авах үйл ажиллагааг ажиглах;
- Санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж, саналын хайрцаг болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;
- Санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хороонд мэдэгдэж залруулахыг хүсэх;
- Сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;
- Хэсгийн хорооны гишүүдээс мэдээлэл авах;
- Ажиглалтын тайланг бодит тоо, баримтад тулгуурлан гаргах;
- Санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас авах;
- Цахим хэлбэрээр хуулбарласан саналын хуудасны зурган мэдээллийг авах;
- Сонгогчдын нэрийн жагсаалтад орж байгаа өөрчлөлттэй танилцах, уг жагсаалтыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэх.

Ажиглагчийн эрх нь хэсгийн хорооноос ажиглагчийн үнэмлэх авснаар эхэлж, санал хураалтын дүн гарснаар дуусгавар болдог.

Б.УУГАНЦЭЦЭГ: СОНГУУЛЬД ОРОЛЦОГЧДЫН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ПРОЦЕССЫГ ЦАХИМ СИСТЕМЭЭР ЯВУУЛНА



Сонгуулийн мэдээллийн цахим систем
(<https://www.e-election.mn/>)-ийн ашиглалтын
талаар Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх
Мэдээллийн технологийн төвийн ахлах
мэргэжилтэн Б.Ууганцэцэгтэй ярилцлаа.



-Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар <https://www.e-election.mn/> цахим системийг сонгуулийн байгууллага, нэр дэвшигч, сонгогч зэрэг өргөн хүрээнд ашигласан. Орон нутгийн сонгуулиар цахим системийг яаж ашиглах вэ?

-Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах бүх үйл ажиллагааг иргэд сонгогчид болон сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс хөндлөнгийн хяналт тавих боломжийг бүрдүүлэн нээлттэй, ил тод зохион байгуулахад онцгой анхаарч ажилласан. Тухайлбал, сонгуулийн дата мэдээллийн үндсэн бааз бүрдүүлэх, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны бүх төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор сонгуулийн мэдээллийн цахим систем хөгжүүлснээр судалгаа, шинжилгээний үндсэн датаг бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа.

Бид Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд цахим системийг нэвтрүүлэхдээ сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагааг цахимжуулах, төр өөрт байгаа мэдээллийг иргэдээс нэхэхгүй байх зарчмыг баримталж ажилласан. Сонгуулийн бүх шатны хороодод ажиллах албан хаагчдын нөөцийг системд бүрдүүлсэн буюу нийт 41 мянга гаруй албан хаагчид сонгуульд ажиллахаар сургалтад хамрагдаж нөөцөд бүртгэгдсэн. Үүнээс 24 мянга гаруй төрийн албан хаагчид системийн хэрэглэгчээр бүртгэгдэж сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд оролцлоо. Уг системээр зөвхөн сонгуулийн байгууллагын ажилтнууд төдийгүй сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам эвсэл, нэр дэвшигчид, тэдгээрийн менежер, шадар туслах, ухуулагч, ажиглагч,

сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгсэл, сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтнууд зэрэг маш олон бүртгэлийг цахимаар зохион байгууллаа. Энэ удаагийн сонгуульд ажиллагаанд оролцогчдын бүртгэл, үйл ажиллагааны процессыг цахим системээр явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

-Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, хэсгийн хороодод ажиллах төрийн албан хаагчдыг системээр дахин бүртгэж, гэрчилгээжүүлэх үү. Эсвэл Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар бүрдүүлсэн хүний нөөц орон нутгийн сонгуульд ажиллах уу?

-Сонгуулийн байгууллагад ажиллах хүсэлтэй төрийн албан хаагчид цахимаар нээлттэй бүртгүүлж, дараа нь цахим сургалтад хамрагдаж шалгалт өгснөөр нөөцөд орж гэрчилгээ авдаг. Хэрвээ Та төрийн албан хаагч мөн л бол энэ гэрчилгээгээр дараагийн сонгуулиудад ажиллах нөөцөд бүртгэлтэй хэвээр байна. Шинээр ажиллах бол системийн сургалтад хамрагдаж, шалгалтаа өгөн гэрчилгээ авч болно. Бид хуулийн дагуу төрийн албан хаагчдаасаа сонгуулийн бүх шатны хороодод ажиллах албан хаагчдаа бүрдүүлдэг. Одоогийн байдлаар ажиллах нөөцийн ихэнх нь өмнөх сонгуульд ажилласан албан хаагчид байна.

-Цахим системд бүртгүүлж, гэрчилгээ авсан албан хаагчид орон нутгийн сонгуульд ажиллахдаа ямар хүсэлт, хэрхэн гаргах вэ?

-Системийг ашиглах явцад хэрэглэгчдээс ирүүлсэн саналд тулгуурлан хөгжүүлэлтүүд хийгддэг. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар албан хаагч өөрөө ажиллах хэсгээ сонгож хүсэлт илгээдэг

байсан бол энэ удаа аль ч талаас сонгох уян хатан нөхцөлтэй болгож сайжруулсан. Иймээс системийн сургалтад хамрагдаж нөөцөд байгаа төрийн албан хаагчдыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд үндэслэн дээд шатны сонгуулийн хороодын дарга, холбогдох ажилтнууд томилох боломжтой.

-Нам, эвсэл, нэр дэвшигчид цахим системийг хэрхэн ашиглах вэ. Ер нь системд нам, эвсэл, нэр дэвшигчидтэй холбоотой ямар бүртгэл хийгдэх вэ. Бүртгүүлэхдээ анхаарах асуудлыг зөвлөөч.

-Тухайн сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг системд бүртгэх бөгөөд тухайн нам, эвсэл нь нэр дэвшигчдээ эрх үүсгэх 2 хүртэл ажилтнаа зохих шатны сонгуулийн хороонд ирүүлнэ. Системд нэр дэвшигчээр бүртгэгдсэн нэр дэвшигчийн хувьд төрийн байгууллагуудаас авдаг 10 гаруй төрлийн лавлагаа мэдээллийг сонгуулийн цахим системээс гаргаж авах боломжтой. Өөрөөр хэлбэл, төрд байгаа цахимжуулсан мэдээллийг ХҮР системээс дуудаж ашиглаж болно. Цахимаар гарах боломжгүй лавлагаа, мэдээллийг холбогдох байгууллагаас нь авч хавсралтаар оруулан нэр дэвших хүсэлтээ цахимаар илгээнэ. Энэ нь цаасан баримтын нэгэн адил хүчинтэй байна. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар бид цахим болон цаасан байдлаар хослуулан зохион байгуулсан. Нэр дэвшигчид нэр дэвших хүсэлтээ аль ч хэлбэрээр гаргах эрх нь бий. Орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчийн бүртгэл, нэр дэвших хүсэлт илгээх, бүртгэх эсэх зэрэг үйл ажиллагаануудыг бид 100 хувь цахим системээр зохион байгуулахаар ажиллаж байна. Үүний тулд зохих шатны сонгуулийн хороодод ажиллах албан хаагчдаа сургаж бэлтгэн ажиллана.

Бас нэг онцлог нь сонгуулийн мэдээллийн сангийн цахим системийг хөгжүүлэхдээ гар утасны

аппликэйшнтэй хослуулан ашиглаж байгаа. Үүгээр дамжуулан бие даан нэр дэвшигч дэмжигчийн бүртгэлээ цахимаар зохион байгуулах боломжтой. Сонгуулийн ерөнхий хорооноос энэ талд дээр дараах 3 хувилбарыг санал болгож байгаа. Нэгдүгээрт, сонгогч өөрөө e-election аппликэйшнд ДАН системээр нэвтрэн ороход тухайн сонгуульд таны байнга оршин суугаа хаягийн дагуу бие даан нэр дэвшихээр бүртгүүлсэн горилогчдын жагсаалт гарч ирэх бөгөөд үүнээс дэмжиж буй хүнээ сонгох. Хоёрдугаарт, бие даан нэр дэвшигч өөрийн хэрэглэгчийн эрхээрээ орж өөрийнхөө дэмжиж буй иргэнийг батлагдсан маягтын дагуу бүртгэж баталгаажуулах. Гуравдугаарт, Батлагдсан маягтын дагуу дэмжигчийн мэдээллийг цаасаар цуглуулах, цугларсан мэдээллийг системд бүртгэж оруулах зэрэг боломжтой.

-Сонгогчид <https://www.e-election.mn/> цахим системээс ямар мэдээлэл авах боломжтой вэ? Гар утасны хувилбарыг орон нутгийн сонгуульд ашиглах уу?

-Өмнө хэлсэн гар утасны e-election аппликэйшнийг аль ч төрлийн ухаалаг утсаар татаж ашиглах боломжтой бөгөөд эндээс тухайн сонгуулийн хууль тогтоомж, шийдвэрүүд, цаг хугацааны хуваарь, сонгуулийн хороодын хаяг байршил, ажиллах буй албан хаагчдын тоо, нэр дэвших буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн мэдээллийг харах мөн нам болон нэр дэвшигч мөрийн хөтөлбөрөө системд оруулах юм бол тэр мэдээллийг ч харах боломжтой. Хамгийн гол нь цахим системд оруулж буй сонгуулийн бодит нээлттэй өгөгдлүүдийг сонгогчдод хүргэхдээ энэ аппликэйшнийг ашиглаж байгаа юм. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд <https://www.e-election.mn/> цахим системийн вэб болон гар утасны хувилбарыг аль алиныг нь ашиглана.

-Цахим систем ашигласнаар сонгуулийн байгууллага, нам эвсэл, нэр дэвшигч, сонгогчдод ямар ач холбогдолтойг товч дурдаач.

-Мэдээж, нам эвсэл, сонгогчдын цаг зав, санхүүг хэмнэнэ. Үүнээс гадна сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны нэг гол онцлог бол маш олон төрлийн бүртгэлийн үйл ажиллагаанд суурилдаг бөгөөд энэхүү үйл ажиллагаанаас үүссэн бүх төрлийн дата мэдээллийг мэдээлэл, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байдаг. Бид өмнө нь дан цаасан суурьтай баримтад түшиглэн боловсруулалт хийх шаардлагатай байсан бол энэхүү системийг бүрэн хэмжээнд нэвтрүүлснээр сонгуультай холбоотой бүх төрлийн судалгааг системд бүрдүүлсэн дата мэдээллийг ашиглан хийх боломжтой болж байгаа юм. Энэ нь урт хугацаандаа сонгуулийн үйл ажиллагааны процессын ил тод байдлыг хангах, энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

-Ярилцсанд баярлалаа.

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ, ХЯНАЛТ



Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулиас хойш сонгогчийн санал авах, тоолох болон сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн нэвтрүүлж, ашиглаж байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн санд сонгуулийн эрх бүхий иргэдийн бүртгэлийн нэгдсэн сан, сонгуулийн тойрог, мандат, хэсгийн хороо, хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалт, түүнтэй холбогдох бусад мэдээлэл, сонгуульд нэр дэвшигчид, нам, эвсэл, тэдгээртэй холбогдох бусад мэдээлэл, сонгуулийн хороодын бүрэлдэхүүн, санал хураалтын ирц болон дүн, сонгуулийн

хороодын үйл ажиллагааны талаарх болон хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл байдаг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд "New Image Cast" санал тоолох төхөөрөмжийг хэрэглэх тухай Монгол Улсын Их Хурлын 20 дугаар тогтоол гарсан.

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд ашиглах бэлтгэлийг хангах, сонгуулийн явцад уг системийн хэвийн ажиллагааг хангаж, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, технологийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Мэдээллийн технологийн төвийг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулан ажиллуулдаг.

Аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны дэргэд харьяалах сонгуулийн хороодын үйл ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийн ашиглалтыг хариуцан ажиллах мэдээллийн технологийн багийг Сонгуулийн ерөнхий хороо Мэдээллийн технологийн төвийн саналыг үндэслэн 7 хүртэл хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж ажиллуулахаар хуульчилсан.

**САНАЛ ТООЛОХ
ТӨХӨӨРӨМЖ ГЭЖ
ЮУ ВЭ?**

Санал тоолох төхөөрөмж гэж сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах техник хэрэгслийг хэлнэ

**САНАЛ ТООЛОХ
ТӨХӨӨРӨМЖ
ДАРААХ БАРИМТЫГ
ҮЙЛДДЭГ**



Саналын хуудас

Өндөр нууцлалтай үнэт цаасаар хийгддэг.

Саналын хуудасны зурган мэдээлэл

Сонгогчийн саналын хуудсыг уншсаны дараа санал тоолох төхөөрөмж өөрийнхөө санах ойд сканнердаж зурган мэдээллэ болгон хадгална.

Санал хураалтын тайлан

Санал хураалт дууссны дараа тухайн хэсгийн хорооны ажилчдад болон ажиглагч нарт дүнгийн тайлан буюу баримтыг хэвлэж өгдөг.

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙН ТУХАЙ

СЕХорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Тагнуулын ерөнхий газрын албан хаагчдаас бүрдсэн АЖЛЫН ХЭСЭГ автоматжуулсан системийн хэвийн үйл ажиллагааг шалган туршиж баталгаажуулан гэрчилгээ олгодог

Сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд бэлтгэхээс дуусах хүртэл нам эвсэл, нэр дэвшигч, ТББ, ИНБ-ууд нээлттэй ажигладаг.

Сонгогч таны САНАЛ "НУУЦ" байх зарчмаа үргэлж хадгалдаг.

САНАЛ АВАХ ҮЕЭР ОФФЛАЙН ГОРИМД АЖИЛЛАДАГ



– ХЭСГИЙН ХОРОО
– АЖИГЛАГЧ НАРТ

– СОНГУУЛИЙН ТӨВ
СЕРВЕРТ ИРСЭН ДҮН

– ХЯНАЛТЫН ТООЛЛОГО
100 %

[саналын хуудасны зураг, дүнгийн тайланг өгдөг]

[Санал хураалтын дараа тусгай сүлжээгээр дүнгээ дамжуулдаг бөгөөд 2016 оноос хойш сонгуулийн урьдчилсан дүнг дэлгэцээр шууд дамжуулж байна]

[2012 оноос хойш зохион байгуулсан хяналтын тооллогын дүн огт зөрөөгүй]

Саналын хуудасны зургийг CD-нд хуулах программ нь файлыг автоматаар хольдог тул санал өгсөн дарааллаар байх боломжгүй гэдэгт ИТГЭЛТЭЙ байгаарай.

Санал тоолох төхөөрөмжийн дүнг өөрчлөх, халдлага хийх ямар ч боломжгүй. Дээрх дараалал, баримтжуулалт, мэдээллийг харж, ИТГЭЛ ҮНЭМШЛЭЭ батлаарай.

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ:



Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв



Аймаг, дүүргийн сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн баг



Сонгуулийн хэсгийн хороонд Мэдээллийн технологийн даамал хариуцан ажилладаг.

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛИАР ХОЛИМОГ ТОГТОЛЦООГООР

126 ГИШҮҮН СОНГОЛОО

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн ээлжит сонгуулийг амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу анх удаа Улсын Их Хурлын 126 гишүүнийг сонгуулийн хосолсон тогтолцоогоор сонгосон нь зохион байгуулалтын болоод эрх зүйн орчны хувьд өргөн цар хүрээг хамарсан онцлогтой, түүхэн сонгууль байв.

Томсгосон тойрогт, холимог тогтолцоогоор олон нам эвсэл, нэр дэвшигчээс сонголт хийх сорилт тулгарсан ч сонгогчид 69.85 хувийн ирцтэйгээр Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэн Монгол төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хуралд төлөөллөө сонголоо.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гадаад улсад байгаа иргэдээ анх удаа цахимаар бүртгэж, дөрвөн

өдөр буюу 2024 оны 6 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд 47 салбарт комисст зохион байгуулж, сонгогчид өндөр идэвхтэйгээр сонгуульд оролцсон юм.

Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд 19 нам, 2 эвслээс болон бие даан нэр дэвшигч нийт 1341 хүн нэр дэвшин өрсөлдөв.

Сонгуулийн дүнгээр Монгол ардын намаас сонгуулийн тойрогт 50, намын жагсаалтаар 18 нийт 68, Ардчилсан намаас сонгуулийн тойрогт 26, намын жагсаалтаар 16 нийт 42, ХҮН намаас сонгуулийн тойрогт 2, намын жагсаалтаар 6 нийт 8, Үндэсний эвслийн жагсаалтаар 4, Иргэний зориг ногоон намаас жагсаалтаар 4 нэр дэвшигч тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдлоо.

Сонгогдсон нийт Улсын Их Хурлын гишүүдийн 32 буюу 25.4 хувь нь эмэгтэй байгаа нь Монгол Улсын парламентын түүхэн дээд үзүүлэлт төдийгүй Ази тивийн дунджаас өндөр үзүүлэлт

бөгөөд дэлхийн 187 орны парламентад эзлэх эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтийг хангасан байна. Мөн шинэ сонгогдсон гишүүдийн хамгийн залуу нь 27 настай бол хамгийн ахмад нь 73 настай байна. Насны ангиллаар авч үзвэл 27-36 настай буюу 4 хувь, 37-45 настай 47 буюу 37.3 хувь, 46-55 настай 60 буюу 47.6 хувь, 56-73 настай 14 буюу 11.1 хувь байна. Мэргэжил боловсролын байдлаар ангилан авч үзвэл инженер 17, хуульч, эрх зүйч 29, бизнес, эдийн засаг, санхүүгийн чиглэлийн 40, хэл судлал, гадаад харилцааны чиглэлийн 8, багш 8, эмч 5, сэтгүүлч 5, улс төр судлаач 4, геологич, дизайнер, жүжигчин, зураач, социологич, физикч зэрэг мэргэжилтнүүд сонгогджээ.


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ДҮН

2024 оны 07-р сарын 01



Улсын Их Хурлын гишүүн



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.

Сонгогч Та өөрийн өгсөн саналдаа ямар ч
эргэлзээгүй, итгэлтэй байж болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

СОНГУУЛИЙН ДҮН: ТОЙРОГТ

Тойргоор, намаар, хүйсээр




Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо, 2024 оны 07-р сарын 01-ны байдлаар. Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ

СОНГУУЛИЙН ДҮН: ЖАГСААЛТААР

Тойргоор, намаар, хүйсээр



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо, 2024 оны 07-р сарын 01-ны байдлаар. Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу санал хураалт дууссаны дараа 2198 хэсэгт 100 хувь гар аргаар хяналтын тооллогыг тасралтгүй 13-56 цагийн турш нам, эвсэл нэр дэвшигчдийн 29680 ажиглагчдын болон камерын хяналт дор хийсэн бөгөөд санал тоолох төхөөрөмжийн дүн хяналтын тооллогын дүнтэй бүрэн тохирсон.

Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийг зохион байгуулахад аймаг, нийслэлийн 22 сонгуулийн хороо, сум, дүүргийн 339 сонгуулийн хороо, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв комисс болон 47 салбар комисс, 2198 хэсгийн хороонд нийт 21943 төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч, мэдээллийн технологийн 2763 албан хаагч ажилласнаас гадна, онцгой нөхцөл байдалд сонгогдынхоо санал авах ажилд онцгой байдлын 530 гаруй албан хаагч, эрүүл мэндийн байгууллагын 1000 гаруй ажилтан ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын сонгууль Монгол Улсад төдийгүй дэлхий дахинд бүрэн нээлттэй болдог. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч болон төрийн бус байгууллага санал авах байранд хоёр хүртэл ажиглагч томилж ажиллуулах эрхтэй. Сонгуулийн зохион байгуулалт, үйл явц дотоод, гадаадын сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад ч бүрэн нээлттэй байдаг.

Энэ удаагийн сонгуульд оролцогч нам, эвсэл болон нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах зардлын ил тод байдлыг хангах, сонгогчдын зүгээс мэдээлэл авч сонголтоо хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор нэр дэвшигчдийн хөрөнгө орлого, иргэн хуулийн этгээдээс авсан хандив, сонгуулийн явцад зарцуулсан зардал зэргийн нээлттэй байдлыг хангах зохицуулалтын хүрээнд явагдсанаараа онцлог.

Энэ удаагийн сонгуулийг ажиглахаар Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газрын Сонгууль ажиглах тусгай багийн 29 орны (АНУ, Серби, Унгар, Грек, Словак, Польш, Монтенегро, Тажикистан, Орос, Казахстан, Узбекистан, Герман, Австри, Ирланд, Итали, Чех, Франц, Норвеги, Недерланд, Швед, Дани, Албани, Умард Македон, Болгар, Азербайжан, Эстони, финлянд, Румын, Испани) 187 ажиглагч, Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны 3 ажиглагч, Филиппин, Энэтхэг, Узбекистан, Казахстан, Орос, Гүрж, Киргиз улсын Сонгуулийн төв комиссын 16 ажиглагч, түүнчлэн Их Британи, АНУ, Япон, Австрали, Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдын 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиглагчдын баг ажилласан. Мөн манай улсад үйл ажиллагаа явуулж буй Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Конрад-Аденауэрын сан, Бритиш колумбын их сургуулийн төлөөлөл ажиглалаа.

Сонгогчдыг мэдээллээр хангах, сонгуулийн үйл явцыг сурвалжилж, мэдээ мэдээллийг шуурхай түгээхэд хувь нэмрээ оруулахаар гадаадын 40 шахам, дотоодын 434 хэвлэл мэдээллийн 4600 гаруй сэтгүүлч, зураглаач, инженер техникийн ажилтнууд хүчин зүтгэл гаргаж, идэвхийлэн ажиллалаа.

**АЖИГЛАГЧДЫН ДҮГНЭЛТЭЭС**

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газрын Сонгууль ажиглах тусгай багийн урьдчилсан дүгнэлтээс...

“Сонгуулийн Ерөнхий Хороо мэргэжлийн өндөр түвшинд ил тод ажиллаж, сонгуульд оролцогч талуудын итгэлийг хүлээн сонгуулийн өмнө сонгогчдод зориулсан мэдээлэл сурталчилгааг цогцоор нь явуулсан. Сонгуулийн өдөр орон даяар тайван байлаа. Сонгуулийн ажиглагчдын хувьд санал хураах үйл явцыг даган ажиглаж, эерэг дүгнэлт хийсэн боловч сонгуулийн хэсгийн хороодын зохион байгуулалт, хүн амын хэт ачааллаас шалтгаалсан нь санал хураах үйл явцад сөргөөр нөлөөлж зарим тохиолдолд санал хураалтын нууцлалыг алдагдуулсан байна.



Сонгуулийн өдөр нь тайван, баяр ёслолын байдалтай өнгөрсөн ба бидний ажиглалт хийсэн санал хураах байрны хэсгийн хороодын гишүүдийн ажил хэрэгч байдал, мэргэжлийн ур чадвар биднийг гайхшируулсан ба тэдгээр гишүүдийн дийлэнх нь эмэгтэйчүүд ажиллаж байсан юм.





Мөн өндөр настай сонгогчид санал өгөх үүргээ илүүтэй бийлүүлж харин залуучуудын хувьд энэ нь сул байгааг тэмдэглэв. Энэ бахдам, сайхан улсын ирээдүй тэдний гарт байгаа бөгөөд эдгээр хүмүүст улс төрийн хүрээнийхэн хүрч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Ерөнхийдөө Монгол Улсын сонгуульд ашигласан технологийн дэвшлүүд санал хураалтын үйл явцыг ил тод, үр дүнтэй явуулахад хувь нэмэр оруулж байна”...

“БОДЛОГОД ЗАЛУУСЫН ХЯНАЛТ” ТББ-ЫН ШУДАРГА СОНГУУЛИЙН ТӨЛӨӨ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХЯНАЛТ СҮЛЖЭЭНИЙ 240 АЖИГЛАГЧИЙН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТЭЭС...



“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явц хуулийн хүрээнд явагдсан ба сонгуулийн дүнд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэжээ. Ажиглалт хийсэн хэсгийн хороод дээр зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна”...







UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gesm@m-election.mn
(976) -51 262127